



СҮХБААТАР



СҮХБААТАР

# Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан

Сүхбаатар хот  
2018 он

## АГУУЛГА

1. Удирдлага, зохион байгуулалт.....	4 - 6
2. Аудитын үйл ажиллагаа.....	7 - 36
3. Сургалт.....	37 - 42
4. Дотоод ажил.....	43 - 52
5. Дүгнэлт, санал.....	53
6. Статистик мэдээ.....	
7. Үр өгөөжийн тайлан.....	
8. Сахилгын шийтгэл ногдуулсан албан шаардлага, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал .....	

### Товчилсон үгийн тайлбар

<b>ААНБ</b>	Аж ахуй нэгж байгууллага
<b>АТГ</b>	Авлигатай тэмцэх газар
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>БОАЖС</b>	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>МДС</b>	Магистр, докторын сургууль
<b>МНБ</b>	Мэргэшсэн нягтлан бодогч
<b>МСҮТ</b>	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
<b>МУ</b>	Монгол улс
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>НТШ</b>	Нээлттэй тендер шалгаруулалт
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ОНӨҮГ</b>	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СТАУС</b>	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТБОНӨХБАҮХА</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үзүүлэлт
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын Газар
<b>ХАА</b>	Хөдөө аж ахуй
<b>ХААИС</b>	Хөдөө аж ахуйн их сургууль
<b>ХК</b>	Хувьцаат компани
<b>ХХААГ</b>	Хүнс хөдөө аж ахуйн газар
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>ХХААЯ</b>	Хүнс хөдөө аж ахуйн яам
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ЭБАТ</b>	Эрх бүхий албан тушаалтан
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

Үндэсний Аудитын Газрын Тамгын газраас өгсөн чиглэл, бүтцийн дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:

### ***НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ***

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Сэдэв батлах тухай” 03-р тогтоол, ҮАГ-ын 2018 оны “Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

нэгдсэн төлөвлөгөө”, 2018 онд төрийн аудитын байгууллагын системийн хэмжээгээр дэвшүүлсэн “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд 2018 оны үйл ажиллагаагаа чиглүүлэн, 33 ажил төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.



*Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь өнөөгийн байдлаар дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор-3, аудитор-4, жолооч зэрэг нийт 10 үндсэн ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.*

Батлагдсан төсөв, орон тооны хүрээнд 12 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулахаас ахлах аудитор Б.Наранчимэг 03 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон өндөр насны тэтгэвэрт гарсан, аудитор Э.Эрдэнэзул Австрали улсад магистрын сургалтад хамрагдахаар 06 дугаар сарын 11-ний өдрөөр, аудитор Ц.Уртнасан өөрийн хүсэлтээр 10 дугаар сарын 19-ний өдрөөр тус тус тасалбар болгон албан тушаалаас чөлөөлөгдөн, аудитор З.Золбоо 10 дугаар сарын 26-ны өдөр томилогдсоноор өнөөгийн байдлаар 10 ажиллагсадтайгаар буюу 2 орон тоо дутуу үйл ажиллагаа явуулж байна.

2018 онд хуанлийн 252 ажлын өдөр буюу 3024 хүн/өдөр ажиллахаас аудитын ачаалал болон орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан нийт 321 өдөр, 3852 хүн/өдөр ажиллаж, 69 өдөр буюу 828 хүн/өдөр илүү ажилласан байна.



2018 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад туслах 2 гэрээт ажилтныг 3 сарын хугацаатайгаар авч ажиллуулсан бол байгууллагын нягтлан бодох бүртгэл, бичиг хэргийн ажил үүргийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гэрээт ажилтнаар гүйцэтгүүлж байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийж гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг МУ-ын Ерөнхий аудиторовын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А /125 дугаар тушаалаар шинэчлэн баталснаар “Халамжийн сангийн үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудит, “Газрын тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитуудыг хасаж, “Сэлэнгэ АЗЗА компанийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудит нэмэгдсэн болно.


Ингэснээр тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 314 байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит, Ерөнхий аудиторовын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 6, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрийн төлөвлөгөө хөтөлбөрөөр 1 зэрэг нийт 9 гүйцэтгэлийн аудит, нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 2, өөрийн төлөвлөгөөгөөр 1, нийт 3 нийцлийн аудит тус тус хийж гүйцэтгэлээ.

2018 онд хийгдсэн аудитуудаар нийт 39,416.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс бүртгэл тайлагналтай холбоотой 6,494.5 сая төгрөгийн алдааг залруулж, 98.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 7,933.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан

шаардлага бичиж, 24,889.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөн, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар 89.5 сая төгрөгийн акт, 4,670.2 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлэн, хэрэгжих хугацаа болоогүй 1,897.7 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжээд байна.



2017 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл, тайлант онд нийт 111.9 сая төгрөгийн акт, 5,940.0 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, актын биелэлт 90.8 хувьтай, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй албан шаардлагын дүнг хасаж тооцвол албан шаардлагын биелэлт 81.3 хувьтай тайлагнагдлаа. /График 3/



2018 онд хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд үндэслэн арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 82, бүртгэл тайлагналтай холбоотой 206, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 238, дотоод хяналтыг сайжруулах 87, бусад чиглэлээр 14 гэх мэтчилэн нийт 626 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 82.7 хувь нь биелэгдсэн дүн мэдээтэй тайлагнагдсан болно.

Холбогдох хууль, тогтоол, шийдвэр, стандартыг ханган ажиллаагүйгээс санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь их хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, **“Хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт”** авсан 44, жилийн эцсийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримт материалыг хуулийн цаглаварт хугацаанд нь ирүүлээгүй, хүнсний тайланг тухай бүр гаргаагүй, хүнсний материалын зарцуулалтад холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт хийгдээгүйгээс жилийн эцэст хасах үлдэгдэлтэй тайлагнагдаж **“Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1**, аудитын үйл ажиллагаанд хүндрэл саад учруулан шаардсан баримт, материалыг ирүүлээгүй 1, гүйцэтгэлийн аудитаар их хэмжээний материаллаг алдаа зөрчил илэрсэн 2 зэрэг нийт 48 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, биелэлтийг нь бүрэн хангуулж ажиллалаа.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авалтыг шууд

худалдан авах аргаар гүйцэтгэсэн, өөрийн шууд хамаарал бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн 3 албан тушаалтныг аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн Эдийн засгийн албанд шилжүүлснийг хэрэг нээж мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байна гэсэн хариуг тус газрын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 46/1-3899 дугаар албан бичгээр ирүүлээд байна.

2018 онд тус газрын хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнгээр нийт 6,610.4 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн, харилцагчид хүлээн зөвшөөрснөөр төсвийн зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 27.3 төгрөгт хүрлээ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь хийж гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмжийг хэрэглэгчдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд аудитын тайлангууд, цаг үеийн ажлууд болон байгууллагын танилцуулга, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангуудыг [AUDIT.MN](http://AUDIT.MN) цахим хуудсаар, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, холбогдох бусад үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд нь [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) нэгдсэн цахим хуудсаар нийтэд мэдээлж байна.

Аудитын тайланг аймгийн ИТХ-ын бүх гишүүдэд цахимаар, ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга нар болон аудит хийгдсэн байгууллагуудад хэвлэн хүргүүлж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн болон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2019 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах санал бэлдэж, аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оруулан танилцуулав.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас холбогдох хууль<sup>1</sup>, журмын<sup>2</sup> дагуу төрийн өмчийн 1, орон нутгийн өмчийн 10 аж ахуйн нэгж болон 3 МСҮТ, 12 сумын ЗДТГ, боловсролын 67 байгууллага зэрэг нийт 93 байгууллагын 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийлгэхээр хараат бус аудитын 5 компанитай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжүүлэн ажилласан болно.




Санхүүгийн тайлангийн аудитад нийт 314 байгууллага, аж ахуйн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн

<sup>1</sup> МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дахь заалт

<sup>2</sup> МУ-ын Ерөнхий аудиторын 2009 оны 108 тоот тушаалаар батлагдсан “Гэрээгээр аудит хийлгэх журам”

аудиторуудаар 221, хараат бус аудитын 5 компаниар 93 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгүүллээ.


Аудитад хамрагдсан 314 байгууллагын 8-д нь Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж, 74 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 232 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргасан байна.



Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 184-д нь “Зөрчилгүй”, 45-д нь “Хязгаарлалттай”, 2-д нь “Сөрөг” санал-дүгнэлт өгсөн бол 1 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 821 төрлийн 12,981.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6,494.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 94.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,590.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 4,802.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

График-4 /сая.төг/



**Актын биелэлт:** Өмнөх оны үлдэгдлээс 17.4 сая төгрөг, тайлант онд тогтоогдсон актаас 85.0 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 91.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд 9.1 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.

**Албан шаардлагын биелэлт:** Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,590.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн бөгөөд өмнөх оны албан шаардлагын үлдэгдлээс 174.0 сая төгрөгийн, тайлант хугацааны 1,311.6 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулснаар нийт дүнгээр 84.4 хувийн биелэлттэй тайлагнагдаж, 278.5 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжээд байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 45 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.



**Зөвлөмжийн хэрэгжилт:** Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 67, бүртгэл тайлагналтай холбоотой 190, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 188, дотоод хяналтыг сайжруулах 62, бусад 4 зэрэг нийт 511 зөвлөмж өгсөнөөс 89,2 хувь болох 456 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 3 албан тушаалтныг шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн бөгөөд хэрэг нээж мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулж байна гэсэн хариуг ирүүлээд байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,025.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн ба өөрийн аудиторуудын хийж, гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын бүх үе шатны ажлыг СТАУС программаар гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудитад 11 хүн 884 хүн өдөр, 53.1 сая төгрөг зарцуулж, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 564 цаг илүү ажиллалаа.

### **Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэлээ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 17 санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймаг, сумдын ерөнхий орлогын болон зардлын дансдын 39 санхүүгийн тайлан, орон нутгийн төсвийн байгууллагын 46, тусгай зориулалтын шилжүүлгийн 127 байгууллага, төсөл сангийн 18, орон нутгийн өмчит 13 үйлдвэрийн газар зэрэг нийт 260 санхүүгийн тайланд аудит хийж, үүнээс 74 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан, нийт 186 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргасан байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3,160.9 сая төгрөгийн материаллаг, 6,714.9 сая төгрөгийн материаллаг бус зэрэг нийт 9,875.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,923.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 50.7 сая төгрөгийн зөрчлийг холбогдох байгууллага, хувь хүмүүсээр төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 1,040.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага, 3,860.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй асуудлууд илэрсэн тул Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203

дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.20.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан **77,044.7** сая төгрөгийн орлого, **76,839.4** сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг аудитаар баталгаажуулав.

***Аймаг, сумдын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан.***

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,425.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,264.3 сая төгрөгийн алдааг залруулж, 7.8 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 542.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага, 1,611.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/134 дугаар тушаалаар 5 сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “Зөрчилгүй” санал-дүгнэлт өгөгдсөн бол 12 сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд гурвалсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг ХХК-иуд, 17 сумдын ТЕЗ-ийн санхүүгийн тайлан, 34 төсвийн шууд захирагчийн, аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын 18, зардлын 21 дансдын зэрэг 90 санхүүгийн тайланд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, 46 дүгнэлт гаргав. Үүнээс аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын 18, зардлын 21 дансдын санхүүгийн тайлан, сумдын ИТХ-ын 17 санхүүгийн тайлан зэрэг 56 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан дүнг аймаг, сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтэд нэгтгэсэн болно.

Төсвийн шууд захирагч нарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитад нийт 29 байгууллагыг хамруулж, 24 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 5 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 12 сумын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Хүдэр, Хушаат, Орхонтуул, Шаамар, Ерөө сумдын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

***Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан***

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг ерөнхий боловсролын сургууль 33, хүүхдийн цэцэрлэг 34, соёлын төв 19, дуу бүжгийн чуулга 2, номын сан 2, орон нутгийн музей 1, биеийн тамир спорт хороо 6, хүүхдийн байгууллага 2, ГХБХБГ 1, ЭМТ 20, өрхийн ЭМТ 7 зэрэг нийт 127 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,738.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,408.0 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 39.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 54.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага, 1,236.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн 67 байгууллагын санхүүгийн тайланд гурвалсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг ХХК-иуд, 60 байгууллагын санхүүгийн тайланд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийлээ. Үүнээс 103 байгууллагын санхүүгийн тайланд **”Зөрчилгүй”**, 23 байгууллагын санхүүгийн тайланд **“Хязгаарлалттай”** санал дүгнэлт тус тус өгөгдөж, 1 байгууллагын санхүүгийн тайланд **“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”** байна.

### **Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2017 оны санхүүгийн тайлан**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 13 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу гурвалсан гэрээгээр “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар, “Дундманхайдай аудит” ХХК, “ЦЭСБ аудит” зэрэг хувийн аудитын компаниудаар орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлж, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь “Сэлэнгэ баялаг ирээдүй”, “Мандал хишиг хайрхан”, “Хүдэр тохижилт” зэрэг 3 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийж, ТЕЗ-ийн тайланд нэгтгүүлэв.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,440.0 сая төгрөгийн материаллаг бус, 1,156.3 сая төгрөгийн материаллаг зэрэг нийт 2,596.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс аудитын явцад 1,177.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 438.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 976.8 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагуудыг холбогдох аж ахуйн нэгжийн удирдлагууд хүлээн зөвшөөрсөн бөгөөд 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”**, 9 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд **“Хязгаарлалттай”**, 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд **“Сөрөг”** санал дүгнэлт тус тус өглөө.

### **Улсын төсвийн байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан**

Улсын төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,105.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,570.6 сая төгрөгийн алдааг залруулж, 43.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 549.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага, 941.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/134 дугаар тушаалаар 3 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “Зөрчилгүй” санал-дүгнэлт өгөгдсөн бол гурвалсан гэрээний дагуу 3 байгууллагын санхүүгийн тайланд “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар, “Пийк Ом аудит” ХХК, “Дундманхайдай аудит” ХХК, 38 байгууллагын санхүүгийн тайланд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийлээ.

Үүнээс 42 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт тус тус өгсөн болно.

### **Төрийн өмчит аж ахуйн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтын дагуу гурвалсан гэрээгээр “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэв.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-д хийсэн аудитаар 547.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 535.1 сая төгрөгийн алдааг залруулж, 11.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэн, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

### **ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

Тайлант онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 6, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрсдийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1 зэрэг нийт 9 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.

**Актын биелэлт:** Өмнөх оны үлдэгдлээс 5.0 сая төгрөгийг, тайлант онд тогтоосон актаас 4.5 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 81.2 хувьтай тайлагнагдсан бөгөөд 2.2 сая төгрөгийн актын төлбөр дараа онд шилжээд байна.

**Албан шаардлагын биелэлт:** Өмнөх оноос шилжиж ирсэн 972.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн 4,446.0 сая төгрөгийн албан шаардлагаас 3,358.6 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлснээр 75,5 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Өмнөх оны үлдэгдэл 33, тайлант оны 70 зэрэг нийт 103 зөвлөмжөөс 79.6 хувь буюу 82 зөвлөмжийг хэрэгжүүлсэн бөгөөд 21 зөвлөмжийн хэрэгжүүлэх хугацаа болоогүйгээс дараа онд шилжээд байна.

Гүйцэтгэлийн аудитаар 1,761.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа.

### **УАГ-ЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРӨӨР**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

Аудитаар “Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендерт үнийн санал ирээгүй, ирүүлсэн тендер шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр 60,7 хувийг нь шууд гэрээ байгуулах аргаар, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөгдсөн байна.

2017 онд Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,486.6 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж, эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2- т заасны дагуу аймгийн дараа оны төсвийг өмнөх оны 12 сарын 05-наас өмнө батлахдаа хөрөнгө, санхүүгийн нөөц боломжоо бүрэн гүйцэт, бодитоор тооцоогүйгээс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхгүйгээр тайлант он гарсан хойно 2 удаагийн төсвийн тодотгол хийж, 2017 оны 11 сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор өмнөх оноос шилжих 16, шинээр эхлэх 54 зэрэг нийт 70 төсөл, арга хэмжээнд 1,687.5 сая /нэг тэрбум зургаан зуун наян долоон сая таван зуун мянга / төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгохоор эцэслэн баталсан байна.

Сүүлийн тодотголыг он дуусахаас сар гаруйхан хугацааны өмнө төлөвлөж байгаа нь тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, улмаар гүйцэтгэл, хэрэгжилтийн ажлууд оройтох, зарим ажлыг хэрэгжсэний дараа нь төлөвлөх, үүний улмаас баримт материалыг хуурамчаар бүрдүүлэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал, Шаамар сумын зөгийн өвөлжөө байгуулах, Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцанд халаах хэрэгсэл тавих, Хилийн цэргийн 101 дүгээр ангийн урсгал засвар, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын мах хадгалах зоорины хөргөлтийн тоног, төхөөрөмжийн засвар, шинэчлэлтийн, шинэ худалдааны төвийн агааржуулалт, кондейшн тавих ажлуудыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдахаас өмнө хийж гүйцэтгэсэн буюу өөрөөр хэлбэл ажил хийгдсэний дараа санхүүжилтийг нь төлөвлөсөнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагааны баримтуудыг төсөв батлагдсан хугацаанд нь тохируулан хуурамчаар бүрдүүлсэн бол аймгийн Татварын хэлтэст тоног, төхөөрөмж худалдан авах арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь оройтож, тоног төхөөрөмжийг он гарсны дараа нийлүүлсэн байхад хүлээн авсан актыг 2017 оны 12-р сарын 22-нд бүрдүүлсэн байна.

Аймгийн хэмжээний хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, мөрдөөгүйгээс 2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг бус урсгал засвар, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах зэрэг цаг үеийн шаардлагатай жижиглэсэн төсөл, арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж, баталсан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. Үүнд: 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 68 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс 1 нь нээлттэй тендер шалгаруулалтын босго үнэд хүрсэн бол 46 нь харьцуулалтын аргаар, 21 нь шууд худалдан авах аргаар хэрэгжсэн буюу нийт төсөл арга хэмжээний 67.6 хувь нь 10.0-80.0 сая төгрөгийн өртгөөр, 30.9 хувь нь 10.0 хүртэлх сая төгрөгөөр хэрэгжсэн байна.

ТБОНӨХБАУХА тухай хуулийн 45.6-д “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил үйлчилгээний эрхийг шилжүүлж болно” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар орон нутгийн төсвөөр

хэрэгжсэн нийт 68 төсөл, арга хэмжээнээс 40 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлж, 28-ыг нь аймгийн ОНАГ хэрэгжүүлсэн нь сумдын мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар дутуугаас харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал хүргүүлэлгүйгээр болон тендерийн үнэлгээг үнэлгээний хуудсаар баталгаажуулалгүйгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл шаардсан ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрөлгүй компанийг сонгон шалгаруулах, зэргээр худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулахгүй байх зөрчил гарч байна. Тухайлбал, Сүхбаатар болон бусад 12 сум нь эрх шилжсэн 274.0 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, Сүхбаатар сум нь 235.0 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулалгүйгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бол Сүхбаатар сум нь 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах”, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарилах төвийн засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрөлгүй компанийг сонгон шалгаруулсан байна.

2017 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд зураг төсөв хийгдээгүй 764.2 сая төгрөгийн өртөг бүхий 29 төсөл, арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн нь хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдах, хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэх тендерт санал ирэхгүй байх, үүний улмаас шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх нөхцөл болж байна. 2017 онд харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендерт үнийн санал ирээгүй, ирүүлсэн тендер шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр 60.7 хувийг нь шууд гэрээ байгуулах аргаар, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн нь хөрөнгө, эх үүсвэрийг үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна.

Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах “Ажлын хэсэг”-т 3-5 хүнийг тогтмол томилон ажиллуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна. Гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ зохион байгуулсан орон нутгийн төсвийн 16 төсөл, арга хэмжээний “ Ажлын хэсэг”-ийг тус газрын даргын тушаалаар тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн Д.Октябрийг бүх ажлын хэсгийн даргаар буюу нийт 16 удаа, гишүүнээр мэргэжилтэн Д.Ариунтуулыг 15 удаа, Х.Нэргүйбаатарыг 14 удаа томилсон бол аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн 3 хүнийг тус бүр 1 удаа томилж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг ганц ч оруулаагүй байна.

Аудитаар зураг, төсвийг урьдчилан хийгээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид алданги тооцоогүй зэрэг нийт **1,988.5** сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд эдгээр зөрчлийг цаашид таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах 2 албан шаардлага өгч биелэлтэд нь хяналт тавин ажиллалаа.



Аудитын дүнд үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тухайн байгууллагын урсгал зардалд суулгаж болох жижиглэсэн ажил, арга хэмжээг бус барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг тусгаж, хэрэгжүүлэх, дотоод хяналт, шалгалтыг сайжруулах зэрэг **16** зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлээгүй, тендерийн баримт материалыг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулаагүй Сүхбаатар сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага бичиж, хэрэгжилтийг нь хангуулан ажиллалаа.

Аудитад 4 хүн, 58 хүн өдөрт 15.0 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 48 цаг илүү ажиллан, 796.5 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.

*Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад хийх аудит*

*Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2017 онуудад хэрэгжиж эхэлсэн боловч ашиглалтад ороогүй 9 барилга байгууламжид холбогдох судалгааг Гүйцэтгэлийн аудитын газраас ирүүлсэн маягтын дагуу гаргаж хүргүүлсэн.*

ҮАГ-аас томилогдсон хөндлөнгийн шинжээчдийн хамт Ерөө сумын Үйлчилгээний төв, Шаамар сумын Дулаанхаан тосгоны 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын болон Алтанбулаг сумын Чөлөөт бүсийн Алтанбулаг-Сүхбаатарын 25 км бохир усны шугам хоолойн ажлуудыг газар дээр нь үзэж, холбогдох баримт материал, тайлбарыг ҮАГ-т хүргүүллээ.

Аудитад 2 хүн, 5 хүн өдөрт 0.4 сая төгрөг зарцуулан ажиллав.

*Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлт*

Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн 385 төсөл, 9 хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэхээр олгосон 22,692.2 сая төгрөгийн 91 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийлээ.

Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэхээр олгосон 91 төсөл, хөтөлбөрийн 46 нь газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөрийн хүрээнд олгогдсон бөгөөд нийт зээл олгосон төслийн 80.2 хувь нь буюу 73 нь хэрэгжсэн байна.

Тухайн орон нутагт төсөл хэрэгжиж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг газар дээр нь тулган баталгаажуулалт хийж, дамжуулан зээлийн нэгдсэн судалгааг гарган, холбогдох нотлох баримтын хамт УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитад 3 хүн, 12 хүн өдөрт 1.3 сая төгрөг зарцуулан ажиллалаа.

*Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн*

*Аудитаар “Аймаг, сумдын төрийн сангийн нэгжийг төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий биеэ даасан нэгжийн зохион байгуулалтад оруулах шаардлагатай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөгдсөн байна.*

Төсвийн тухай хуулийн 36.1-д “Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ”, 36.2 “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд байна” гэж заасан байдаг.

Гэтэл аймаг, сумдын төрийн сангийн нэгжийг тухайн шатны ЗДТГ-ын дэргэд бус бүтэц орон тоонд нь багтааж зохион байгуулсан нь Төсвийн тухай хуульд заасан тогтолцоо бүрэн хэрэгжихгүй, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэх нөхцөл боломжгүй байдалд хүргэж байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан төрийн сангийн тогтолцоонд аймаг, нийслэл, сум, дүүрэг гэсэн засаг захиргааны нэгжүүдэд төрийн сан байхаар хуульчилсан боловч Сэлэнгэ аймгийн хувьд сумдаасаа алслагдсан Бугант, Дулаанхан тосгодод тус бүр төрийн сангийн төлөөлөгч, төрийн сангийн мэргэжилтэн гэсэн 2 хүн ажиллаж байгаа бол сумдтайгаа ойр байрладаг Түнхэл, Хэрх, Номгон, Рашаант зэрэг 4 тосгонд төрийн сангийн мэргэжилтэн ажиллаж байгаа нь хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна.

Бидний гүйцэтгэсэн аудитын дүнгээс харахад төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, бүртгэх тайлагнах, санхүүжүүлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг аймагт ЗДТГ-ын СТСХ, сумдад Санхүүгийн алба хамтатган хэрэгжүүлж байгаа нь төсвийн захирагчийн холбогдох хууль тогтоомж зөрчин төлөвлөж, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл



арга, хэмжээг санхүүжүүлэх, төсвийн зарлагын дарааллыг журмын дагуу тогтоох, бүлэглэсэн дүнгээр хяналт тавих үндсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Иймээс төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, тайлагнах чиг үүргийг төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжүүлэх чиг үүргээс салгаж, зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Сумдын Санхүүгийн алба байгуулах тухай Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолд тосгоны талаар тодорхой зааж өгөөгүйгээс тосгодод Санхүүгийн албаны зохион байгуулалт хийгдээгүй байна. Дулаанхаан тосгоны төрийн сангийн мэргэжилтэн нь захирагчийн албаны, Бугант тосгоны төрийн сангийн төлөөлөгч нь захирагчийн албаны, төрийн сангийн мэргэжилтэн нь сургууль, соёлын төвийн нягтлан бодогчийн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцоонд тавих төрийн сангийн хяналтыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Санхүүгийн алба зохион байгуулагдсан 14 суманд нэг нягтлан бодогч дунджаар 3-5 байгууллага хариуцаж, 1 орон тооны цалин авч байгаа бол зохион байгуулагдаагүй 3 сум болон тосгоны төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нар 1-2 байгууллагыг хариуцан, үндсэн байгууллагаас авч буй цалин хөлсөн дээр хавсран ажилласны 30-40 хувийн нэмэгдэл цалин авч байна. Ингэснээр сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалт нь сум, тосгодод харилцан адилгүйгээс 1 нягтлан бодогчид ногдож буй байгууллагын тоо болон цалин хөлс, нэмэгдэл нь эрс ялгавартай байдлыг үүсгэж, цөөн байгууллага хариуцсан нягтлан бодогч их цалин авдаг, олон байгууллага хариуцсан нягтлан бодогч бага цалин авдаг тогтолцоотой болж, ижил хөдөлмөрт ижил цалин хөлс олгох зарчим алдагдсан байна.

Иймээс сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг нэн даруй өөрчлөн, нягтлан бодогчийн ажлын ачаалал, цалин хөлсний ялгавартай байдлыг арилгах нь зүйтэй юм.

Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүйгээс дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- *Хушаат сумын төрийн сангийн нэгж сонгуулийн зардлын дансанд 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгааг маягтын дагуу гаргуулж, нотариатаар батлуулалгүйгээр нийт 5.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хийсэн,*
- *Сумдын төрийн сангийн нэгжүүд баталгаат гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажаагүй төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтээр нийт 101.7 сая төгрөгийн гүйлгээг хийсэн,*
- *Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд анхан шатны баримтын бүрдэл дутуу хяналтын хуудсаар нийт 264.8 сая төгрөгийн гүйлгээг хийсэн байна.*
- *Журмаар зөвшөөрөгдсөн нийт 269.1 сая төгрөгийн орлого бууруулах гүйлгээг хийхдээ журналын ордер, бүртгэлийн дансны орлогыг хуулгыг хавсаргаагүй,*
- *Төрийн сангийн үйл ажиллагааны журмаар хориглосон бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн орлогыг бууруулж 1.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн, худалдан авах ажиллагаа нь хуулийн дагуу зохион байгуулагдаагүй төсөл арга хэмжээнд 485.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.*
- *Бугант тосгоны төрийн сан төсвийн байгууллагын нийт 2.2 сая төгрөгийн төлбөр, тооцоог төлбөрийн хүсэлт бичигдсэнээс хойш ажлын 3 өдрөөс илүү хугацааны дараа хянаж, баталгаажуулсан,*

- Төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ төрийн сангийн тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулалгүйгээр нийт 11.8 сая төгрөгийн гүйлгээ хийсэн,
- Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд 2,284.7 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтыг сарын дундуур хийсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд төсвийн жилийн эхэнд харьяа төсвийн байгууллагуудаас жижиг мөнгөн сангийн хэмжээг тогтоолгох хүсэлтийг хүлээн авч, хязгаарыг тогтоогоогүй,
- Төсвийн байгууллагуудын төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайлан, картын дансны хуулыг хүлээн авч хяналгүйгээр дараагийн жижиг мөнгөн сангийн зузаатгалын нийт **82.9 сая төгрөгийн гүйлгээг хийсэн,**
- Сайхан сумын төсвийн байгууллагууд 2017 онд арилжааны банканд төлбөрийн картын данс нээлгээгүй байснаас шалтгаалж цалингийн түр дансаар 11.8 сая төгрөгийн, Алтанбулаг сумын сургууль нь цалингийн түр дансаар дамжуулж нийт 0.4 сая төгрөгийн, Зүүнбүрэн сумын ЗДТГ нь нярвын харилцах дансаар 4.3 сая төгрөгийн, Шаамар сумын сургууль, цэцэрлэг 0.6 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг тус тус хийсэн,
- Зарим сумдын төрийн сангийн нэгжүүд “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2, 6.3-д заасныг зөрчин төсөвт байгууллагын жижиг мөнгөн сангийн баталсан хязгаараас давсан нийт **166.5 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг санхүүжүүлсэн.**

Аудитаар дээр дурдсанчлан нийт 4,738.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс. 464.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 4,274.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 11 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2018 оны Төсвийн хуулийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

Аудитаар “Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан зайлшгүй нөхцөл, шаардлага үүсээгүй байхад аймаг, сумдын төсөвт тус бүр 1-2 удаа тодотгол хийж, төсвийн орлого, зарлагыг **714.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна**” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

УИХ-аас 2018 оны аймгийн төсвийн /сумдын төсөв орохгүйгээр/ суурь орлогыг **12,202.9** сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг **11,749.4** сая төгрөгөөр, татварын бус орлогыг **427.0** сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг **26.5** сая төгрөгөөр тус тус хянаж ирүүлсэн байна.

УИХ-аас хянаж ирүүлсэн аймгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор **1,068.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, үүнээс Цемент шохой компаниас олон жил дамжин авч чадаагүй ХХОАТ-ын авлагаас **319.4** сая төгрөг, усны төлбөрийн авлагаас **197.6** сая төгрөг, Орон нутгийн өмчийн газрын өөрийн орлогоос **6.0** сая төгрөг, 2017 оны мөнгөн хөрөнгийн

болон ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 545.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр тооцож, **13,271.4** сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6,945.1 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 3,838.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 47,014.7 сая төгрөгөөр тус тус тооцож, Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн нийт орлогыг **71,069.9** сая төгрөгөөр баталсан байна.

УИХ-аар хянагдаж ирсэн усны төлбөрийн орлого 452.4 сая төгрөгийг 197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 650.0 сая төгрөгөөр баталсан ч 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 162.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар УИХ-аар хянагдаж ирсэн усны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-аар хий өсгөн төлөвлөсөн нь гүйцэтгэлээр биелдэггүй атал нэмж баталсан хэмжээгээр аймгийн ИТХ, ЗДТГ, Засаг даргын нөөц сангийн зардлыг өсгөж төлөвлөдөг зөрчил 2018 онд ч давтагдан гарсан байна.

УИХ-аас хянагдаж ирсэн орлогыг аймгийн ИТХ-аар **1,068.5** сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотойгоор аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 238.5 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын зардлыг 80.0 сая төгрөгөөр, Засаг даргын үйл ажиллагааны болон аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлыг 292.0 сая төгрөгөөр, цаг агаарт зориудаар нөлөөлөх зардлыг 30.0 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын зардлыг 6.0 сая төгрөгөөр, гэрэлтүүлгийн зардлыг 54.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилтийг 45.5 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 40.0 сая төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 282.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчин зураг, төсөв хийгдээгүй **762.5** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих нийт 68 төсөл, арга хэмжээний 14-г нь шууд худалдан авалтын арга, 45-г нь харьцуулалтын арга, 9-г нь нээлттэй тендерийн аргаар сонгон шалгаруулах босго үнэд багтаан төлөвлөсөн бөгөөд нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой дараах төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн байна. Үүнд:

- Цагааннуур сумын сургуулийн 1, 2 дугаар байрны камержуулалтын ажилд тус бүр 6.0 сая төгрөгийг,
- Цагааннуур сумын хичээлийн А байрны засварын ажилд 7.0 сая төгрөгийг, самбарын засвар, тохижилтын ажилд 5.0 сая төгрөгийг, /1 компаниар гүйцэтгүүлсэн/;
- Алтанбулаг суманд цэнгэлдэх хүрээлэн барих ажилд 80.0 сая төгрөгийг, морь барианы талбай барих ажилд 20.0 сая төгрөгийн ажлыг /1 компаниар гүйцэтгүүлсэн/;
- Орхонтуул сумын ЗДТГ, соёлын төвийн дээвэр засвар 65.0 сая төгрөгийг, сантехникийн засварын ажилд 24.0 сая төгрөгийн /1 компаниар гүйцэтгүүлсэн/ ажлууд зэрэг болно.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн / сумд ороогүй / орлого, зарлагыг анх **71,069.9** сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны 3-р улирлын байдлаар аймгийн төсөвт 1, сумдын төсөвт 1-2 удаа тодотгол хийгдсэнээр 2018 оны орон нутгийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг **79,496.2 / сумдын төсөв орсон /**сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Үүнээс Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчин зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсөвт 100,0 сая төгрөгийн, сумдын төсөвт нийт **614.0** сая төгрөгийн тодотгол хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор 14 хөтөлбөр, 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодотгон баталсан боловч төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөрийг арга хэмжээгээр нь задлаагүй, хүрэх үр дүнгийн тоон үзүүлэлтийг тусгаж батлаагүй байна.

Аудитаар шаардлага үүсээгүй байхад зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор төсөвт тодотгол хийсэн, Засгийн газраас нөөц сангаас олгосон санхүүжилтийг төсөвт сууж батлагдаагүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 төсөл, арга хэмжээнд нэмэлт ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүйгээр нэмэлт санхүүжилт олгосон зэрэг нийт 2,113.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс **774.1** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,339.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллаж байна.

Аудитад 7 хүн 149 хүн өдөрт 9.3 сая төгрөг зарцуулан, ажлын ачааллаас шалтгаалан 120 цаг илүү ажиллан, 419.4 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

*Монгол Улсын алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт*

*Аудиттай холбоотой манай аймагт алтны орд ашиглах лиценз эзэмшигчид, тэдгээрийн 2015-2018 оны Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө, тайлан, нөхөн сэргээлтийн талаарх судалгааг Гүйцэтгэлийн аудитын газраас ирүүлсэн маягтын дагуу гарган хүргүүллээ.*

### Аймгийн ИТХ-ын захиалгаар

*Жавхлант, Хушаат, Сүхбаатар сумдын ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн*

Аудитаар "Ойн хандив, тусламжийн орлогоос Сүхбаатар сум 3.5 сая төгрөг, Жавхлант сум 1.4 сая төгрөг зэрэг нийт 4.9 сая төгрөгийг төлөвлөгдөөгүй ажил гүйцэтгэх, бусдад хандив өгөх зэргээр зориулалт бусаар зарцуулсан байна" гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын 3.3 дахь заалт, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015

оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймагт сум, байгууллагын хэмжээнд тэгш ой тэмдэглэхэд зөвшөөрөл олгох журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 18 дугаар тогтоол, Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор Сүхбаатар сум байгуулагдсаны 80 жилийн ойг, Жавхлант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар тогтоолоор Жавхлант сум байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар сумын 80 жилийн ойд бэлтгэх, ойн баярыг зохион байгуулах ажлын хэсгийн 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ –ийн дарга М.Суурьбат ойн арга хэмжээнд зарцуулагдах анхны төсвийг 369.4 сая төгрөг байхаар танилцуулсан бол 2 дахь төсвийг 402.7 сая төгрөгөөр төлөвлөж, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хандив, тусламж өгөхийг уриалан Хаан банк, Төрийн банк, Голомт банкинд төвлөрүүлэхээр харилцах данс нээсэн байна.

Гүйцэтгэлээр ААНБ, иргэдээс нийт 370.3 сая төгрөгийн мөнгөн, 185.4 сая төгрөгийн биет зэрэг нийт **555.7 сая** төгрөгийн хандив, тусламж төвлөрүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 153.0 сая төгрөгөөр илүү буюу 138.0 хувийн биелэлттэй байна.



Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор сумын 40 жилийн ойн хандивыг төвлөрүүлэн зарцуулах төсвийг нийт 230.1 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан боловч гүйцэтгэлээр 201.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөсөн хэмжээнээс 29.1 сая төгрөгөөр бага буюу 87.4 хувийн биелэлттэй байна.

Аудитаар ойг тэмдэглэх ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй, төлөвлөгдөөгүй ажил гүйцэтгэх, бусдад хандив өгөх зэргээр хандив, тусламжийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан, хандив, тусламжийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт, шалгалт хийгдээгүй зэрэг нийт **437.7 сая** төгрөгийн зөрчил илрүүлэн, 2 албан шаардлага өгсөн бөгөөд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллалаа.

Аудитын үйл ажиллагаанд хүндрэл саад учруулан, шаардсан баримт, материалыг ирүүлээгүй Хушаат сумын Засаг даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн ТЕЗ-д хүргүүлснийг биелүүлсэн тухай хариу ирүүлээд байна.

Аудитад 4 хүн 25 хүн өдөрт 6.1 сая төгрөг зарцуулан, ажлын ачааллаас шалтгаалан 48 цаг илүү ажиллан, 237.5 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, үр дүн

Аудитаар “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих дотоод хяналт, шалгалт хангалтгүйгээс орлого дутуу төвлөрч байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126 дугаар тогтоолоор сум дундын ойн ангиудыг байгуулсан байна.

Уг тогтоолд Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийг Ерөө суманд, Хараагийн бүсийн сум дундын ойн ангийг Мандал суманд, Орхоны бүсийн сум дундын ойн ангийг Баруунбүрэн суманд, Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд тус тус байршуулан байгуулжээ. Аймгийн ИТХ-ын 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 105 дугаар тогтоолоор Сэлэнгэ-Бэлчирийн бүсийн сум дундын ойн ангийг Цагааннуур суманд байршуулахаар өөрчлөлт оруулсан байна.

Хүдэр сумын ИТХ-ын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 116 дугаар тогтоолоор “Хүдэр сумын ойн анги” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2017 онд ойгоос хэрэглээний мод 79,130 м3, түлээний мод 84,005 м3 бэлтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр хэрэглээний мод 56,817.3 м3, түлээний мод 48,964.5 м3 бэлтгэсэн байна.



Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогод 771.2 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 773.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 100.2 хувьтай тайлагнагдсан байна.

2017 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг БОАЖС-аас 281750 м3 –ээр хянаж ирүүлсэн бол аймгийн ИТХ-аар 275790 м3-ээр, сумдын ИТХ-аар 163135 м3 -ээр тус тус эцэслэн баталсан нь хянагдаж ирсэн хязгаараас 112655 м3-ээр буюу 40,8 хувиар буурсан байна.

Сумдын ИТХ-аас ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг Сүхбаатар, Сайхан, Орхонтуул сумдаас бусад 14 суманд анх 471.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд бэлтгэх модны дээд хязгаарт өөрчлөлт ороогүй байхад орлогын төлөвлөгөөнд 2-4 удаагийн тодотгол хийн 299.4 сая төгрөгөөр буюу 63.5 хувиар нэмж, 771.2 сая төгрөгөөр баталжээ.

Аудитаар мод түлээ бэлтгэх эрхийн бичгийн дүнг буруу бичсэн, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, төлбөрийн үлдэгдлийг аж ахуйн нэгж, нөхөрлөлтэй тооцоо нийлж, баталгаажуулаагүй зэрэг нийт **164.2 сая төгрөгийн** зөрчил илэрснээс **1.9 сая төгрөгийн** зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, **162.3 сая төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, биелэлтийг нь бүрэн хангуулав.

Ойгоос мод бэлтгэх зөвшөөрөл олгох болон түүнээс төвлөрүүлэх татварын орлоготой холбоотой их хэмжээний зөрчил гаргасан Ерөө бүсийн сум дундын ойн ангийн даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч биелэлтийг нь хангуулан ажиллалаа.

Аудитад 5 хүн 23 хүн өдөрт 6.4 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 32 цаг илүү ажиллан, 78.7 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

### Өөрийн төлөвлөгөө хөтөлбөрөөр

*Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа*

*Аудитаар “Тус компанийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний алдаа, зөрчил оршиж байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.*


Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тайлант онд 1,500.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,446.7 сая төгрөгийн зарлага гарган, 47.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллах бизнес төлөвлөгөөг баталснаас орлого 36.8 хувиар буюу 551.4 сая төгрөгөөр давж, зарлага 20.3 хувиар буюу 484.4 сая төгрөгөөр хэтрэн, 106.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2017 онд зам засвар, арчлалт, бүтээгдэхүүн борлуулалтын болон бусад үйл ажиллагаанаас нийт 2,417.9 сая төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд 2 ажлын 13.5 сая төгрөгийн орлогыг бүртгэлд огт тусгаагүй, 1 ажлын 59.3 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан байсныг 2018 оны орлогод нөхөн тусгасан байна.

2017 онд 15 төрлийн зардалд 1,446.7 сая төгрөгийг зарцуулахаар баталсан ч гүйцэтгэлээр 29 төрлийн зардалд 1,931.1 сая төгрөгийг зарцуулж, зардлыг 33.5 хувиар буюу 484.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Төлөвлөгдөөгүй болон хэтэрсэн зардлын шалтгааныг судлахад бодитоор төлөвлөөгүйгээс төлөвлөгөөнд тусгаагүй 10 төрлийн 297.8 сая төгрөгийн зайлшгүй зардал, батлагдсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс хэмнэж болох 3 төрлийн 149.1 сая төгрөгийн зардал гарсан бол урьдчилан тооцох боломжгүй, зайлшгүй нөхцөл байдлын улмаас 6 төрлийн 137.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2017 оны жилийн эцсийн авлагыг насжилтаар нь авч үзэхэд 2005-2013 онд үүссэн авлага 13.0 хувийг, 2014-2016 онд үүссэн авлага 63.0 хувийг тайлант онд үүссэн авлага 24.0 хувийг тус тус эзэлж байна.




Тайлант онд Засгийн газрын 2013 оны 68-р тогтоолоор баталсан шууд худалдан авах босго үнэ болох 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 төрлийн 930.6 сая төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэжээ.

Үүнээс үндсэн хөрөнгө, шатахуун, түлш, шатах тослох материал, битум худалдан авах 604.6 сая төгрөгийн худалдан авалтад худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бол 326.0 сая төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт **621.4 сая төгрөгийн** алдаа, зөрчил илэрснээс **2.6 сая төгрөгийн** зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **618.8 сая** төгрөгийн зөрчилд албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн биелэлтийг нь бүрэн хангуулан ажиллалаа.

Аудитад 4 хүн 82 хүн өдөрт 6.9 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 80 цаг илүү ажиллан, 229.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.



Тайлант онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 2, өөрийн төлөвлөгөө хөтөлбөрөөр 1 зэрэг нийт 3 нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, ОНХС, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн сэдэвт 2 нийцлийн аудитын тайланг 2018 оны 12 сарын 03 –ны өдөр шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилт сэдэвт аудит нь 12 дугаар сард гүйцэтгэгдэж дуусах учир эдгээр аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа дараа онд шилжиж, тайлант онд нийцлийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бага хувьтай тооцогдож байна.

**Албан шаардлагын биелэлт:** Өмнөх оноос шилжиж ирсэн 123.8 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн 1,897.7 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт тооцох хугацаа болоогүй тул дараа онд шилжээд байна.

**Зөвлөмжийн хэрэгжилт:** Өмнөх оны үлдэгдэл 14, тайлант оны 44 зэрэг нийт **58** зөвлөмжөөс өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж тайлант оны зөвлөмжийн хэрэгжүүлэх хугацаа болоогүйгээс дараа онд шилжээд байна.

Нийцлийн аудитаар 824.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд өмнөх онд хийгдсэн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах тухай 2 албан шаардлагын хугацаа болоогүйгээс тайлант онд шилжиж ирсэнийг хэрэгжүүлсэн байна.

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт*

АН

*Аудитаар “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, мэдээллээ байршуулаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.*

3



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитад 2017 оны 4-р улирал, 2018 оны 3-р улирлын байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, уг хуулийн үйлчлэлд хамаарах улсын төсвийн 44, орон нутгийн төсвийн 174, аймаг, сумдын ТЕЗ 18, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 14, төрийн өмчит компани 1, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж 97, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ үзүүлж буй байгууллага 55 зэрэг нийт 403 хуулийн этгээдийг хамрууллаа.

Дээрх хуулийн этгээдүүдийн шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн болон мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад ОНӨААТҮГ 2, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 89 аж ахуйн нэгж, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг үзүүлдэг 29 байгууллага зэрэг нийт 120 хуулийн этгээд цэс үүсгээгүй, мэдээлэл байршуулаагүй байна.

Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит 250 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12091 удаагийн мэдээллээс 11260 удаагийн буюу 92.8 хувийг мэдээлсэн байна.

№	Зөвлөлийн өсөл	Зөвлөлийн дугаар	Зөвлөлийн утга	Үний дүн	Шилээрсэн байгууллага	Огноо
1	2018-02-02	4050 2018-0202 ҮАХЗ	Орон нутгийн өмчлөх мэдээллийн байгууллагад тусгай хөрөнгө оруулалт тухай	14,402,000.00	Төвч газрын тусгай мөнгөн хөрөнгийн мөнгөний үйлчилгээний байр ОНӨААТҮГ 2, ТЭЗ-Монгол	2018-02-02
2	2018-10-01	4054	Хөрөнгө гаргах тухай	1,980,000.00	СХЗ	2018-10-01
3	2018-08-24	4027	Бүтээлийн тусламж олгох тухай	1,000,000.00	Я.Мөнхсайхан	2018-08-24
4	2018-05-17	4046	Бүтээлийн тусламж олгох тухай	1,000,000.00	Ш.Очи	2018-05-17

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах 403 хуулийн этгээд нь нийт 12091 удаагийн 111,154.2 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим санд мэдээлэхээс 11260 удаагийн 108,597.7 сая төгрөгийн мэдээллийг байршуулсан нь мэдээлбэл зохих мэдээллийн тооны хувьд 92.8 хувийн, мөнгөн дүнгийн хувьд 97 хувийн хэрэгжилттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасны дагуу 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 155 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 128 аж ахуйн нэгжид /давхардсан тоогоор/ 13,178.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулж, 6,820.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дээрх 155 төсөл арга хэмжээг 97 ААН, байгууллага гүйцэтгэсэн бөгөөд эдгээр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс үүсгэж, нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ЗГ-аас тогтоосон журмын дагуу улирал бүр мэдээлэх ёстойгоос нэг ч ААН, байгууллага мэдээлэл байршуулаагүй, 8 ААН, байгууллага цэс үүсгэсэн боловч мэдээлэл байршуулаагүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах 75 ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 55 хуулийн этгээдэд 3,679.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулж, 2,681.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах 55 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 177 удаагийн мэдээллээс 27 удаагийн мэдээллийг хугацаанд нь, 38 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 36.7 хувийг мэдээлсэн байна

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих **10,208.1 сая** төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрч, холбогдох албан тушаалтанд 5 зөвлөмж өгсөн бөгөөд биелэлтийг тооцох хугацаа болоогүй тул дараа онд шилжээд байна.

Аудитад 5 хүн 75 хүн өдөрт 5.4 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 60 цаг илүү ажиллалаа.

*ОНХС, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн*

*Аудитаар “Аймаг, сумдын удирдлагууд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн холбогдох хууль, журмуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөгдөв.*

#### *ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн*

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4-р сарын 14-ний өдрийн хуулиар ОНХС-аас Сэлэнгэ аймагт хуваарилсан 2,139.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2017 оны 5-р сарын 5-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор аймагт 1,345.1 сая төгрөг, сумдад 794.6 сая төгрөг хуваарилж, баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс өмнөх оноос шилжин ирсэн 2, 2017 онд шинээр эхлэх 6 зэрэг нийт 8 төсөл арга хэмжээнд 704.3 сая төгрөг, аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд 50.0 сая төгрөг, сумдын ОНХС-д 794.6 сая төгрөг, мал эмнэлэг, хот тохижилтын зардалд 725.2 сая төгрөг зэрэг нийт **2,274.1 сая** төгрөг зарцуулахаар баталсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 969.9 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалтыг зөрчсөн байна.

ТЭЗҮ, зураг төсөв, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад тусган, батлуулахаар зохицуулагдсан байдаг атал аймгийн ОНХС-аас 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 төсөл, арга хэмжээнээс 53.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх зардал, 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах зэрэг 2 төсөл, арга хэмжээний зах зээлийн үнийн судалгаа, төсвийг хийлгүйгээр төсөвт өртгийг багцаалан тусгаж, батлуулсан байна

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 100 төсөл, арга хэмжээнээс 8 сум 83 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгэсэн бол 148.1 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг хяналтын зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан байна.



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 1,514.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 1,436.6 сая төгрөгийн өртөгтэй 75 төсөл, арга хэмжээ бүрэн, 77.5 сая төгрөгийн өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 101.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

53.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх”* төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүй шууд худалдан авах аргаар, 31.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засварын ажил”*-ын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Сумдын ажлын хэсэг нь 227.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй бол 322.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа нэг ч үнийн санал ирээгүй болон тендерийн материалын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр тендерийг хүчингүй болгосон боловч шаардлага хангаагүй гэж хасагдсан болон огт үнийн санал ирүүлээгүй аж ахуйн нэгжид шууд гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулан, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлж байгаа нь үнийн харьцуулалт хийж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг сонгох зарчим алдагдаж, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааг НТШ-аар зохион байгуулсан 1, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 зэрэг нийт 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгэхээс 4 төсөл, арга хэмжээний / 1 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй, зөвхөн худалдан авах ажиллагаа нь хийгдсэн / явцын болон техникийн хяналтыг *“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ* гүйцэтгэсэн бол 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Усан бассейны дулааны шугамын ажил”*, 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах”* 2 төсөл, арга хэмжээнд хяналт хийлгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 37.2, Засгийн газрын

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан 25 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс 9 төсөл, арга хэмжээний хяналтыг орон нутгаас, 12 төсөл, арга хэмжээний хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн бол 70.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгээгүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга угсралт, их засварын ажлыг сумын комиссын актаар хүлээн авч байгаа боловч шууд худалдан авах аргаар хэрэгжсэн нийт 104.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг актаар хүлээж аваагүй байхад 18 төсөл, арга хэмжээнд нийт 150.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байгаа нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.10 дахь заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр Сайхан сумын хувийн хэвшлийн “Таеквондогийн Мараната клуб”-ын барилгын гадна, дотно сантехникийн ажилд 58,0 сая төгрөг төлөвлөж хэрэгжүүлсэн нь ОНХС-гийн зааврын 4.5 дахь “*Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сүхбаатар сум **худалдаа, нийтийн хоолны** чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг ИЗЗИ компанитай байгуулсан гэрээний дагуу 1900 нохой устгуулсан гэж 2 удаагийн гүйлгээгээр 20.0 сая төгрөг шилжүүлсэн боловч устгаж, булсан нохойны тоо хэмжээг нотолж, дэмжсэн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байгаа нь гэрээт ажил үнэхээр хийгдсэн эсэх эргэлзээг төрүүлж байна. Өөрөөр хэлбэл 1900 нохой устгаж, булсан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхой бус байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгасан бол аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 118.5 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын явцад 14 суманд хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг объект дээр нь очиж танилцахад ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал гараагүй болно.



/ Хүдэр сум. Соёлын төвийн өргөтгөл /



/ Орхонтуул сум. Тоглоомын талбай /

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийгээгүй бол 10 сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл, хийгдсэн хөрөнгө оруулалтын чанар байдалд 1-2 удаа хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Харин Зүүнбүрэн, Сант, Сүхбаатар сумдын ИТХ нь Хяналтын хороог байгуулаагүй, Алтанбулаг, Ерөө, Хушаат, Шаамар сумдын ИТХ нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй Хяналтын хороог байгуулсан боловч хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй бол аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Зүүнбүрэн, Түшиг, Шаамар сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн гэх боловч ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

ОНХС-ийн 2017 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар аймгийн хэмжээнд нийт 1,986.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,706.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 280.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт тооцох хугацаа болоогүй учир дараа онд шилжээд байна.

#### *Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн*

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 2.1-д улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, буцалтгүй тусламж, сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги зэрэг орлогоос сангийн хөрөнгийг бүрдүүлэхээр заасан байдаг.

2017 онд аймгийн хэмжээний 17 сумын Сум хөгжүүлэх санд дээр дурдсан эх үүсвэрүүдээс зөвхөн 2-оос нь буюу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгээс орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, бүрдүүлсэн бол гэрээнд заасны дагуу хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги тооцож, орлого бүрдүүлэхээр төлөвлөөгүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.2-т “*Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна*” гэж заасан байна.

Сумдууд 2017 онд зээлийн эргэн төлөлтөөс 656.6 сая төгрөгийн, зээлийн хүүгийн орлогоос 43.6 сая төгрөгийн зэрэг нийт 700.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 86 төсөл сонгон шалгаруулан, 491.6 сая төгрөгийн зээл олгосон байна.

2017 онд аймгийн хэмжээний нийт сумдын дүнгээр зээлийн эргэн төлөлт болон зээлийн хүүгийн орлогоос нийт 1,780.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч эргэн төлөлтөөс 656.6 сая төгрөгийн, хүүгээс 43.6 сая төгрөгийн зэрэг нийт 700.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээр орлогын төлөвлөгөө 39.3 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Журмын 1.7-д заасны дагуу гэрээний хугацаа хэтэрсэн зээлд алданги ногдуулахаар журамлагдсан атал, тооцож, ногдуулаагүйгээс нийт сумдын дүнгээр 123.9 сая төгрөгийн алдангийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11 дэх заалтын дагуу 2017 оны байдлаар нийт эх үүсвэрийн 20 хувийг нөхөн бүрдүүлээгүйн улмаас Сэлэнгэ аймгийн 17 сумаас 11 сум нь нийт 86 төсөлд 491,6 сая төгрөгийн зээл олгож, бусад 6 сум зээл олгоогүй байна.

Олгосон зээлийг салбараар нь ангилж үзвэл хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд 24.4 хувийг, үйлчилгээний чиглэлд 19.8 хувийг, мал аж ахуйн чиглэлд 17.4 хувийг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд 9.3 хувийг, газар тариалангийн чиглэлд 8.1 хувийг, барилгын чиглэлд 7.0 хувийг, худалдааны чиглэлд 5.8 хувийг, бусад чиглэлд 8.1 хувийг олгосон байна.

Нийт 63 төсөлд 1.0-5.0 хүртэлх сая төгрөгийн зээл олгосон байгаа нь нийт зээлийн 73.2 хувийг эзэлж байна.

Ингэж СХС-ийн зээлийг хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих, тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх гэхээсээ илүү иргэдийн өдөр тутмын амьжиргаанд зориулан олгож байгаа мэт харагдаж, зээлийн үр дүн, үр өгөөжийг бууруулж байна.

Зээл олгохдоо хэдийгээр барьцаа хөрөнгийн гэрээ хийж байгаа ч уг гэрээг улсын бүртгэлээр баталгаажуулаагүй, хөдлөх хөрөнгийн / машин техник, мал амьтан, гэрийн тавилга г.м/ эзэмших эрхийг шилжүүлж аваагүй зэрэг зөрчил түгээмэл байгаа нь барьцаалсан хөрөнгүүд бодит байдал дээр барьцаалагдаж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл барьцаалсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрх нь зээл авсан иргэн, аж ахуйн нэгжид хэвээр хадгалагдаж, зээл төлөх хөшүүрэг болж чадахгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт муу байна.



“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.6 -дахь заалтын дагуу 2017 онд 11 сум 86 төсөлд 491.6 сая төгрөгийн зээлийг жилд 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосон байна.

Аудитын явцад зээл олгосон 11 суманд хүрч, зээлдэгчид авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг тулган баталгаажуулахад нийт зээлийн 4.2 хувь буюу 20.5 сая төгрөгийн 6 төслийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа огт явуулаагүй бол 10.8 хувь буюу сая төгрөгийн 53.0 сая төгрөгийн 9 төсөл хэрэгжиж байгаад зогссон, 2.0 хувь буюу нэг удаагийн шинжтэй 10.0 сая төгрөгийн 1 төсөл хэрэгжээд дууссан бол 5.7 хувь буюу 28.0 сая төгрөгийн 5 төсөл түр зогссон байна.

Аудитын дүнгээс харахад сумын ИТХ-аас сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх ажил хангалтгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн журамд аймгийн ХХААГ-ын болон сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн, сангийн нягтлан бодох бүртгэл хариуцах ажилтнуудын эрх, үүргийн талаар огт тусгаагүй байгаагаас сангийн санхүүгийн тайланг тусгайлан сумын ИТХ-д тайлагнадаггүй, аймгийн ХХААГ сумдаас сар бүр мэдээ авч нэгтгэн ХХААХҮЯ-д хүргүүлдэг ч мэдээний үнэн зөв, бодитой эсэхэд хяналт тавьдаггүй байна.

Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 2,926.5 сая төгрөгийн 734 зээл байгаагаас 4.9 хувь буюу 7 сумын 19.8 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол 5.9 хувь буюу 222.2 сая төгрөгийн 44 зээлийг төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан, 23.3 хувь буюу 957.3 сая төгрөгийн 171 зээлийг төлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн, 65.8 хувь буюу 1,727.2 сая төгрөгийн 483 зээлдэгчид хугацаандаа эргэн төлөлт хийх мэдэгдэл хүргүүлсэн байна.

СХС-ийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар нийт **4,153.2 сая төгрөгийн** зөрчил илэрснээс **191.0 сая төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага, **3,962.2 сая төгрөгийн** зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт тооцох хугацаа болоогүй учир дараа онд шилжээд байна.

ОНХС, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитад 5 хүн 65 хүн өдөрт 4.6 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 40 цаг илүү ажиллан, 824.1 сая төгрөгийн үр өгөөж тооцон харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

*Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилт*

*Аудитаар “Сонгон шалгаруулалтгүйгээр удирдах болон төрийн албаны жинхэнэ албан тушаалд томилдог зөрчил оршсоор байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.*

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 208 төр, төсвийн байгууллагад 6050 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 77.3 хувь нь төрийн үйлчилгээний, 13.9 хувь нь төрийн захиргааны, 6.9 хувь нь төрийн тусгай, 1.9 хувь нь улс төрийн албан хаагч байна. Графикаар харуулбал:



2018 оны 09 дүгээр байдлаар нөхөгдөөгүй 4 сул орон тоо байгаа бөгөөд сонгон шалгаруулалтгүйгээр шууд томилсон 16, сонгон шалгаруулалтад ороогүй түр тушаалаар томилогдсон 46 албан хаагч ажиллаж байна.

Аудитаар төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад ороогүй буюу төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлтгүй иргэнийг тухайн албан тушаалд томилдог, ажлын байрны тодорхойлолтод харилцан адилгүй шаардлага тавьдаг, ярилцлагын шалгалтын үнэлгээ, дүгнэлт тодорхой бус байдаг, нөөцөд бүртгэлтэй иргэдээс санал болгодоггүй, албан тушаалын сул орон тооны захиалга өгдөггүй, албан тушаалын захиалга өгөхдөө зохих баримт материалын үнэн зөвийг хянадаггүй зэрэг зөрчил илэрлээ.

Үндэслэлгүй халагдсан ажилтнуудын ажиллаагүй хугацааны цалинг шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, ажиллаагүй хугацааны цалин хөлсийг нөхөн олгох шийдвэр гараагүй байхад олгосон зэрэг 23,274.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй ажиллах 6 зүйлийн зөвлөмж хүргүүлсэн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа дараа онд шилжээд байна.

Аудитад 4 хүн 76 хүн өдөрт 5.4 сая төгрөг зарцуулан, ажлын цар хүрээ ачааллаас шалтгаалан 36 цаг илүү ажиллалаа.

## АЙМГИЙН ИТХ-Д ОРУУЛЖ, ХЭЛЭЛЦҮҮЛСЭН АСУУДЛУУД

### Нэг. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн"-г аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэв.



2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр аймгийн ИТХ-ын дарга болон төлөөлөгчдөд цахимаар хүргүүлж, танилцуулсан бөгөөд 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэв.



1. Төсвийн тухай хуулийн 34.2 –р зүйлд “ Дээд шатны төсөвт тухайн төсөв захирагчид холбогдох тодотгол хийсэн болон урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч, зарлага нэмэгдсэний улмаас төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон зэрэг шалтгаанаас Засаг дарга төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх”-ээр хуульчлагдсан байдаг. Бид өмнөх онд хийсэн аудитаар уг заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгч байсан боловч хэрэгжүүлээгүйн улмаас 2017 онд дээрх нөхцөл байдлууд үүсээгүй байхад буюу төсвийн орлогыг анх батлахдаа тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс үүдэлтэй төлөвлөгөөнөөс давсан орлогыг ихэвчлэн хөрөнгө оруулалтад зарцуулах зориулалтаар аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт тус бүр 3-6 удаа тодотгол хийгдсэн байна.

Цаашид хөрөнгө, орлого, санхүүгийн эх үүсвэрийг тооцоо судалгаан дээр үндэслэн, хуулиар тогтоосон хугацаанд нь бодитоор төлөвлөх замаар дээрх шаардлагууд үүссэнээс бусад тохиолдолд төсвийн тодотгол хийхгүй байхыг зөвлөж байна.

2. Аймгийн 17 сумын төр төсвийн байгууллагуудад 4 ОНӨААТҮГ, 9 хувийн компани, 4 аж ахуйн нэгж байгууллага халаалтын үйлчилгээ үзүүлж байна. Судалгаанаас үзэхэд сумдад халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээгээр ажиллуулж байгаа нь бусдад давуу байдал бий болгон, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулах боломжийг олгож байна. Тухайлбал: 2017 онд 168.0 сая төгрөгийн төсөвтэй Ерөө сумын халаалтын үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгч “Монжим Трейд” ХХК-ийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулж, гүйцэтгүүлсэн байна. Мөн дээрх хувийн компаниуд нь орон нутгийн өмч хөрөнгө, техник, тоног төхөөрөмж ашиглан үйл ажиллагаа явуулж байхад холбогдох хуулийн дагуу түрээс төлүүлж, орлого төвлөрүүлэх ажил огт хийгдээгүй байна.

Цаашид халаалтын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг ТБОНӨХБАҮХТ хуулийн дагуу нээлттэй, тэгш, шударга, өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, холбогдох хуулийн дагуу орон нутгийн өмч хөрөнгө ашигласны түрээсийн төлбөр төлүүлж байх нь зүйтэй юм.

3. Аймгийн ИТХ болон Засаг даргын зүгээс орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бодлого, зохицуулалтын арга хэмжээ хангалтгүйгээс 2017 онд үйл ажиллагаа явуулж, аймгийн ТЕЗ-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 13 аж ахуйн нэгжээс 7 нь үйлдвэрлэлийн үр дүнгээр 1.1-680.5 сая төгрөгийн хооронд нийт 902.8 сая төгрөгийн алдагдал хүлээсэн бөгөөд 12 нь 0,5-1,446.7 сая төгрөгийн хооронд нийт 3,680.0 сая төгрөгийн авлага, 10 нь 1.9-3,837.5 сая төгрөгийн хооронд нийт 6,349.8 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

Иймээс дээрх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах, орлого нэмэгдүүлж, зардлыг хэмнэх замаар үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, зорилтот түвшин, гэрээний биелэлтийг хангуулж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

4. 2017 онд ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 3 төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн төлбөрт байгууллагын батлагдсан төсвөөс нийт 8.5 сая төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт

бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Үүнд: Алтанбулаг сумын ЗДТГ-ын төсвөөс 1.9 сая, Цагааннуур сумын сургуулийн төсвөөс 5.2 сая, Баруунбүрэн сумын ЭМТ-ийн төсвөөс 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулсан байна.

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ "* гэсэн заалтын дагуу төсөвт учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх болно гэдгийг анхааруулж байна. Иймээс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс өөрийн багцад хамаарах төсвийн захирагчдад дээрх байдлын талаар анхааруулж ажиллахыг зөвлөж байна.

5. Өмнөх онд хийгдсэн аудитаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам боловсруулж, баталж, мөрдөх зөвлөмж өгөгдөж байсан боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт суларч, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал, шагнал урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг харилцан адилгүй хэмжээгээр / зарим хүнд дээд тал нь 3.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон бол заримд нь тус бүр 200.0-300.0 мянган төгрөг гэх мэт / олгодог, гадаад, дотоодын уралдаан тэмцээн, бэлтгэл, сургуулилт, сургалтын төлбөр, амьжиргааны дэмжлэг зэргийг олгож буй шалгуур үзүүлэлт тодорхойгүй зэрэг байдал ажиглагдаж байна.

Зардлын гүйцэтгэлийн тайлангийн загвар маягт, заавал хянаж хүлээж авах баримт материалын жагсаалт зэргийг баталж, мөрдөхгүй байгаагаас зардлын гүйцэтгэлийн тайлан үйлддэггүй, анхан шатны баримт материалын үндсэн хувийг бус хуулбар тайлан, анхан шатны баримт зэргийг хүлээн авдаг зэрэг зөрчил нийтлэг байдлаар илэрч байна.

Цаашид аймгийн орон нутгийн онцлогт тохирсон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, тайлагнах журмыг баталж, мөрдөх шаардлагатай байна.

6. Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 2011-2015 оны хооронд аймаг хөгжүүлэх сан / хуучнаар /, сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хугацаа хэтрэлт 7,475.0 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 594.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаад онцгой анхаарч иргэд, аж ахуйн нэгжийн авсан зээлийг төлүүлж, төсвийг хохиролгүй болгох ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй юм.

### **Хоёр. Аймгийн 2019 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар оруулсан санал**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-дэх *"Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, аймгийн ИТХ-д оруулах"* гэсэн бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2019 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулан танилцуулав. / 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын хуралдаанд/

**Аймгийн Засаг даргын өргөн барьсан  
2019 оны орон нутгийн төсвийн төсөлд  
болон төсвийн хөрөнгийн үр ашгийг  
дээшлүүлэх талаар өгөх санал**Сүхбаатар сум  
2018 оны 12 сарын 05

**Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:** УИХ-аас Сэлэнгэ аймгийн 2019 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 14,361.0 сая төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 5,461.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 5,825.4 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 44,660.9 сая төгрөгөөр буюу нийт 70,309.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, ирүүлжээ.

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төслөөр УИХ-аас баталсан суурь орлогыг 3,183.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 73,492.4 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

УИХ-аас баталсан төсвийн суурь орлогыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн газраас оруулсан санал болон өөрсдийн хийсэн тооцоо судалгаан дээр үндэслэн аймгийн Засаг даргаас 3,183.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр өргөн барьсан байна. Оруулж буй саналыг орлогын төрлөөр нь авч үзвэл: Цемент Шохой ХК-иас авах ХХОАТ-ын авлагаас 1,500.1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татвараас 84.0 сая төгрөг, Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 67.4 сая төгрөг, усны төлбөрийн орлогоос 120.0 сая төгрөг, бусад татвар төлбөр хураамжаас 152.0 сая төгрөг, хүүгийн орлогоос 152.5 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр, урьд оны мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлээс нийт 1,200.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр, төсөвт байгууллагын өөрийн орлого болон бусад орлогыг 92.4 сая төгрөгөөр бууруулахаар санал боловсруулсан байна. Үүнээс Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас оруулсан Цемент шохой компанийн ХХОАТ-ын авлагаас **1,500.1 сая төгрөгийн орлого** төвлөрүүлэх саналыг хүлээн авч, төсвийн орлогыг нэмэгдүүлэн батлав.

**Төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар:** Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн 2019 оны нийт суурь зарлагын төлөвлөгөөг УИХ-аас 70,309.1 сая төгрөгөөр баталж, ирүүлснийг суурь орлогыг өсгөсөн хэмжээгээр буюу 3,183.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 73,492.4 сая төгрөгөөр өргөн мэдүүлсэн бөгөөд төсвийн зарлагын дүнд урсгал зардал 90.5 хувь, хөрөнгийн зардал 9.5 хувийг эзэлж байна.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн зарлагыг аймгийн ИТХ-д 540.9 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргад 72,951.5 сая төгрөгөөр зэрэг нийт 73,492.4 сая төгрөгөөр тооцсон байна.

УИХ-аар батлагдсан суурь орлогыг 3,183.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 374.8 сая төгрөгөөр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн болон бусад хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлыг 1,516.4 сая төгрөгөөр, цаг агаарт зориудаар нөлөөлөх зардлыг 30.0 сая төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг 217.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 600.0 сая

төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 444.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр өргөн мэдүүлжээ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 оны орон нутгийн төсвийн зарлагыг бууруулах нийт **185.5 сая төгрөгийн** дараах саналыг оруулсныг хүлээн авч холбогдох хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлав. Үүнд:

- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2.1-7.2.12-т заасан ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй нийт 150.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр өргөн мэдүүлсэн байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заагдаагүй урсгал зардлын шинж чанартай 35.5 сая төгрөгийн 4 төсөл, хөтөлбөрийг байгаль орчныг хамгаалах нөхөн, сэргээх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

## ГУРАВ. СУРГАЛТЫН ТАЛААР

ҮАГ-ын 2018 оны “Мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө” болон өөрийн аудитуудаас авсан санал хүсэлт, судалгааг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны “Мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө” боловсруулан мөрдөж ажиллалаа.

Ингэснээр 2018 онд гадаад сургалтад 1, ҮАГ-аас зохион байгуулсан 5 сургалтад нийт 15 хүн, өөрийн байгууллагаас зохион байгуулсан 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 43 хүн, бусад байгууллагаас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад 15 хүн тус тус хамрагдсан байна. Үүнд:

### Гадаад сургалт



Аудитын менежер Б.Батмөнх БНХАУ-ын Наньжин хотод 2018 оны 1-р сарын 07-14-ний хооронд зохион байгуулагдсан “Залилангийн эрсдэл, материаллаг байдлын түвшинг үнэлэх”, “Чанарын хяналт”, “Бэлчээрийн аудит”, “Их хэмжээний өгөгдөлтэй ажиллах” сэдэвт сургалтад хамрагдлаа.

## ҮАГ-аас зохион байгуулсан сургалт

- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа;
- Үндэсний аудитын газрын чадамжийн хүрээний сургалтад ахлах аудитор С.Баасансүрэн, Ц.Отгонбаяр нар;
- Төрийн аудитын байгууллагын аудитын менежерүүдийн сургалтад аудитын менежер Б.Батмөнх хамрагдав.
- Төрийн аудитын байгууллагын ЭБАТ, нууцын үйл ажиллагаа хариуцсан албан хаагчдын сургалтад ахлах аудитор Ц.Отгонбаяр оролцов.
- Төрийн аудитын байгууллагын мэргэшлийн тасралтгүй хөтөлбөрийн хүрээнд бүсийн сургалт 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд манай аймагт зохион байгуулагдлаа.



Сургалтад Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн нийт 20 албан хаагч оролцож, Үндэсний аудитын газрын Тамгын газрын хүний нөөцийн албаны менежер Ж.Дэмчигсүрэн, ерөнхий санхүүч Ө.Саран, Стратеги удирдлагын газрын арга зүйч, аудитын менежер Ж.Батсайхан, ахлах шинжээч П.Цэнгүүн, шинжээч М.Доржханд, Санхүүгийн аудитын газрын аудитор Ш.Ичинхорлоо нар төрийн аудитын байгууллагын албан хаагчдад сургалтын хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай мэдээллийг өгч, харилцан мэдээлэл солилцлоо.

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх шинэ журам, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүй, аргачлалын өөрчлөлт, шинэчлэлийн талаар сургалт хийж, сэдэв тус бүрээр дадлага ажил зохион байгуулж, дүнг нэгтгэн ярилцаж, Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцооны стратегийн бодлогын баримт бичиг боловсруулахад санал авч, хэлэлцүүлэг явуулсан нь тус сургалтын онцлог байв.



Төрийн аудитын байгууллагад 5, 10 дахь жилдээ ажиллаж буй Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Ц.Отгонбаяр, С.Баасансүрэн, аудитор Б.Эрдэнэзул, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Сувдмаа нар мэргэшлийн түвшин тогтоох шалгалтад хамрагдаж, амжилттай дүгнэгдэн, батламж

### Дотоод сургалт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан дараах сургалтуудад бүх аудиторуудыг хамруулсан болно. Үүнд:

➤ “Худалдан авах ажиллагаанд аудит хийж гүйцэтгэх тухай” сэдэвт сургалтыг аудитор А.Дашбат хийж гүйцэтгэв.

Тус сургалт ерөнхий зүйл, ХАА-нд аудит хийх эрх бүхий байгууллага, ХАА-ны аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө, ХАА-ны аудитын үйл явц, аудитыг төлөвлөх, аудитыг хэрэгжүүлэх, аудитын үр дүнг тайлагнах, аудитын зөвлөмжийн мөрөөр ажиллах гэсэн агуулгын хүрээнд явагдсан бөгөөд сургалтад хамрагдсан аудиторуудыг 2 баг болгон хувааж худалдан авах ажиллагаатай холбоотой “Эрсдэл”-ийн талаар 4 дасгал, гэрээ байгуулахтай холбоотой 3 дасгал, аудитын нотлох зүйлстэй холбоотой 1 дасгал ажиллуулж, боломжит хариун дээр ярилцлага зохион байгууллаа. Мөн ажиллаагүй бусад сэдвийн хүрээнд асуулт, хариулт хэлбэрээр ярилцлага өрнүүлж ажилласан болно.



*/Сургалт хийгдэж буй зураг-2018.06.22-ны өдөр дарга, тэргүүлэх аудиторуудын өрөөнд/*

➤ “Аудитын ажлын баримт бүрдүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг аудитын менежер Б.Батмөнх хийв.

Тус сургалт урьдчилсан судалгааны үе шатны ажлын баримтууд, төлөвлөлтийн үе шатны ажлын баримтууд, гүйцэтгэх үе шатны ажлын баримтууд, тайлагналын үе шатны ажлын баримтууд, аудитын мөрөөр ажиллах үе шат гэсэн агуулгын хүрээнд явагдсан бөгөөд сургалтын төгсгөлд аудитын ажлын баримт бүрдүүлэхтэй холбоотой асуудлаар харилцан ярилцлага хийж, аудиторуудын асуултуудад хариулт өглөө.



*Сургалт явуулж буй зураг-2018.06.29-ний өдөр дарга, тэргүүлэх аудиторын өрөөнд/*

➤ “Санхүүгийн тайлангийн аудитын шинэчлэгдсэн журам, стандарт, арга зүй” сэдэвт сургалтыг аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ нар хийж гүйцэтгэв.


Тус сургалтаар энэ оны санхүүгийн тайлангийн аудитын бодлого, үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг хэрэгжүүлэх бодлого, арга зүй, эрсдэлийн аудит, санхүүгийн тайлангийн аудитад тавих хяналт, үнэлгээний талаар ерөнхий танилцуулгыг хийлээ. Сургалтын төгсгөлд санхүүгийн тайлангийн журамтай холбоотой асуудлаар ярилцлага хийж ажилтнуудын асуултуудад хариулт өгөв.




*/Сургалт явуулж буй зураг-2018.09.18-ны өдөр аудиторуудын өрөөнд/*

➤ “Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох журам”-ын талаар сургалтыг ахлах аудитор, нууц хариуцсан ажилтан Ц.Отгонбаяр хийв.

Тус сургалтаар төрийн болон албаны нууцын тухай ойлголт, эрх зүйн үндэс, хамгаалах тогтолцоо, мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлах, ил болгох, төрийн нууцтай харьцах албан тушаалтан, иргэний үүрэг, хариуцлага, төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам гэсэн агуулгын хүрээнд явагдсан бөгөөд сургалтын төгсгөлд албан хаагчид сонирхсон асуултынхаа хариултыг авч харилцан ярилцах байдлаар сургалтыг үр дүнтэй зохион явууллаа.



*/Сургалт явуулж буй зураг-2018.09.10-ны өдөр дарга, тэргүүлэх аудиторовын өрөөнд/*



Шинээр томилогдсон аудитор З.Золбоод дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх нар Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, төрийн аудитын ажилтны ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль, журмыг танилцуулах ажлын байран дахь сургалтыг зохион байгуулав

- Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад гарч буй зөрчлүүдийг арилгах тухай сургалтыг ЭБАТ Ц. Отгонбаяр зохион байгуулав.



“ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ” СУРГАЛТЫН  
ТАЙЛАН

2018.06.29

Сүхбаатар сум

Төрийн аудитын тухай 14.5-д: “Төрийн аудитын байгууллагын ажилтан үүрэгт ажлаа үр нөлөөтэй гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяагийн баталсан “Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө”-ний дагуу “Худалдан авах ажиллагаанд аудит хийж гүйцэтгэх тухай” сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр дарга, тэргүүлэх аудиторын өрөөнд ажлын байран дахь дотоод сургалтыг зохион байгууллаа.

Сургалтыг дараах агуулгын хүрээнд явууллаа. Үүнд:

- Ерөнхий зүйл
- ХАА-нд аудит хийх эрх бүхий байгууллага
- ХАА-ны аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө
- ХАА-ны аудитын үйл явц
- Аудитыг төлөвлөх
- Аудитыг хэрэгжүүлэх
- Аудитын үр дүнг тайлагнах
- Аудитын зөвлөмжийн мөрөөр ажиллах

Сургалтад дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, С.Баасансүрэн, Ц.Отгонбаяр, аудитор Б.Эрдэнэзул, Ц.Уртнасан, Ж.Цогт, нягтлан бодогч, бичиг хэрэг, архивын ажилтан Б.Наранцэцэг нар оролцлоо.

Сургалтын хүрээнд 2 баг болгон хувааж худалдан авах ажиллагаатай холбоотой “Эрсдэл”-ийн талаар 4 кейс, гэрээ байгуулахтай холбоотой 3 кейс, аудитын нотлох зүйлстэй холбоотой 1 дасгал ажлуулж, боломжит хариун дээр ярилцлага зохион байгууллаа. Мөн ажиллаагүй бусад сэдвийн хүрээнд асуулт, хариулт хэлбэрээр ярилцлага өрнүүлж ажилллаа.



/Сургалт хийгдэж буй зураг-2018.06.22-ны өдөр дарга, тэргүүлэх аудиторын өрөөнд/

Тайлан бичсэн:

Аудитор  А.Дашбат  
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Байгууллагын дотоодод хийсэн сургалтын тайланг тухай бүр хөтөлж, нотлох баримтаар баталгаажуулж хэвшсэн болно.

### **Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт**

ҮАГ болон өөрийн дотооддоо зохион байгуулсан сургалтаас гадна бусад байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад аудиторудыг хамруулав. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай” сургалтад ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор А.Дашбат нар;



Сангийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтад аудитор А.Дашбат, Ж.Цогт нар

- МНБ-ийн эрх олгох шалгалтад бэлтгэх 14 хоногийн сургалтад аудитор А.Дашбат, Э.Эрдэнэзул, Ж.Цогт нар хамрагдан, шалгалт өгч аудитор А.Дашбат МНБ болсон бол аудитор Э.Эрдэнэзул, Ж.Цогт нар 4-5 хичээлийн хөнгөлөлт авсан байна.

➤ Аудитор А.Дашбат ХААИС-ийн эдийн засгийн магистрын эчнээ сургалтад 2 жил сурч эдийн засгийн магистрын цол авсан бол аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Ц.Отгонбаяр, аудитор Б.Эрдэнэзул, Ц.Уртнасан, Ж.Цогт нар Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж буй ХААИС-ийн МДС-ийн бизнесийн удирдлагын магистрын эчнээ сургалтад суралцаж байна. Ингэснээр тус газрын нийт ажилтнуудын 60 орчим хувь нь эдийн засаг, бизнесийн магистрын цолтой болох нөхцөл бүрдэж байна.

➤ Аудитор А.Дашбат Удирдлагын академийн төрийн удирдлагаар мэргэшүүлэх 1 жилийн эчнээ сургалтад суралцаж байна.

## ДӨРӨВ. ДОТООД АЖИЛ

### Архив, бичиг хэрэг, нууцын материал:

2018 онд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 27 тушаал гарч, явсан бичиг 190, албан тоотоор ирсэн бичиг 108, цахимаар ирсэн бичиг 46 тус тус бүртгэгджээ.



2017 онд хийж гүйцэтгэсэн аудитуудын тайлан, ажлын баримт, ирсэн явсан бичиг, дарга, тэргүүлэх аудиторын тушаал болон холбогдох бусад баримт, материалыг архивын нэгж болгон үдэж, хавтаслан, 131 хавтас материалыг байгууллагын архивт хүлээлгэн өгөв.

Тус газар нь нууцын зэрэглэлд багтдаг Хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангиудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэдэг учир эдгээр байгууллагатай харьцсан ирсэн, явсан бичиг, жилийн эцсийн санхүүгийн тайлангууд зэрэг нууцад хамаарах баримт, материалыг нууцын сейфэнд хадгалж, интернэт болон дотоод сүлжээнд холбогдох боломжгүй зөөврийн компьютероор бэлдэн гаргаж байна.

Монгол улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 5 дугаар зүйл “ Нууцын албан хэрэг хөтлөлт”- д заасны дагуу нууцын ажилтны хөтлөх ёстой 12 дэвтрийг нээн хөтөлж байгаа бөгөөд тус журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан нууцлалын 7 ширхэг дардсыг хүлээн авч ашиглаж байна.

Нэгдсэн хөтөлбөрийн дагуу хийгдэх аудит болон хууль, эрхийн актуудын шинэчлэл, өөрчлөлттэй холбоотой 21 судалгааг ҮАГ-т цаг хугацаанд нь гаргаж, хүргүүлэв.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлын тайланг сар бүрийн 25-нд, хүний нөөцийн судалгааг сар бүрийн сүүлийн 7 хоногийн “Пүрэв” гаригт ҮАГ-т мэдээлж байна.

### **Хүний нөөц**

Нийт 10 ажилтны 70.0 хувь нь 5-аас дээш жил тус газарт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ба 60.0 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, жолоочоос бусад бүх ажилтнууд эдийн засаг, статистик, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй.

Тайлант онд ажилтнууд төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм, шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажилласнаар ёс зүйн зөрчил гаргасан ажилтан байхгүй бөгөөд 2017 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, нэгтгэн хүргүүлсэн бөгөөд аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг, сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудиторуудаар гаргуулж хэвшсэн болно.

2018 онд дарга, тэргүүлэх аудиторын зүгээс төрийн жинхэнэ албан хаагч 8 ажилтантай үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагч 1 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хагас жилийн үр дүнгийн гэрээг 4 ажилтан “А”, 4 ажилтан “В” үнэлгээтэй дүгнүүлсэн бол төрийн үйлчилгээний албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг “хангалттай-сайн” үнэлгээтэй үнэлсэн байна. Эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг “А”, “В” үнэлгээтэй дүгнүүлсэн 9 ажилтанд нийт 1,381.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон бол жилийн эцсийн үр дүнгийн гэрээг 8 ажилтан үнэлүүлж, 5 ажилтан “А”, 3 ажилтан “В” үнэлгээтэй, хөдөлмөрийн гэрээг жолооч “хангалттай-сайн” үнэлгээтэй дүгнүүллээ.

Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогч С.Бүрэнбат нарын хооронд байгуулж, эхний хагас жилээр “В” үнэлгээтэй үнэлэгдсэн бол жилийн эцсийн биелэлтийн тайланг гаргаж 2018 оны 12 сарын 05-ны өдөр МУ-ын Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан ажлын албанд хүргүүлэв.

### **Байгууллагын ил тод байдлыг хангах:**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь өөрийн байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа, хийж гүйцэтгэсэн аудитын дүн, тайланг хэрэглэгчдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд 2018 онд 12 аудитын тайлан, үйл ажиллагаатай холбоотой 12 мэдээллийг [AUDIT.MN](http://AUDIT.MN) цахим хуудсанд байршуулсан бөгөөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт болон холбогдох бусад үзүүлэлтүүд зэрэг нийт 123 мэдээллийг хуулийн хугацаанд нь [SHILENDANS.GOV.MN](http://SHILENDANS.GOV.MN) нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байна.

МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Мэдээллийн нэр: "2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц" сэдэвт аудитын тайлан

Мэдээллийн товч агуулга:

УАГ-ын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "2018 оны Төсвийн хуулийн хэрэгжилтийн явц" сэдэвт аудитыг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ныг хүртэлх хугацаанд хийж, гүйцэтгэлээ.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?
- Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн үү?

Илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлт:

Аудитаар нийт 2,113.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 774.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,339.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитын тайлан, дүнг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлан, тайланг УАГ болон аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүллээ.



Удирдлагын зөвлөлийн хурал-2018.11.05 /СТХ-ийн төлөөлөл оролцох/

Мэдээлэл боловсруулсан: Аудитор *А. Дашбат*  
 Шийдвэрлэсэн байдал: *Шийдвэрлэсэн*  
 Олон нийтэд түгээхийг зөвшөөрсөн: *Ч. Энхтуяа*  
 Дарга, тэргүүлэх аудитор: *Ч. Энхтуяа*  
 2018 оны 11 сарын 05 өдөр  
 Мэдээлэл олон нийтэд түгээсэн байдал: *Түгээсэн*  
 Мэдээлэл түгээсэн хэлбэр: *Урлаг, хөгжлийн газрын тусламж, зөвлөмж*  
 Мэдээлэл түгээсэн ажилтан: *А. Дашбат*

Цахим хуудсаар нийтэд мэдээлж буй мэдээллийн үнэн зөвийг хангах үүднээс бэлтгэсэн мэдээллийг дарга, тэргүүлэх аудитор хянаж, тусгай хуудсаар зөвшөөрөл өгсөний дараа байршуулж хэвшлээ.

Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, бүх гишүүдэд цахимаар, аймгийн Засаг дарга болон аудит хийгдсэн байгууллагуудад цаасан сууриар хүргүүлж байна.

Сэлэнгийн мэдээ сонин, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж аудитын тайлан, дүнг цахимаар өгч хэвшлээ.



Хүний нөөцийн болон төсвийн зарцуулалтын ил тод байдлын хүрээнд тус байгууллагад ажиллаж буй бүх ажилтан, албан хаагчдын товч танилцуулга, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ зэргийг самбараар нийтэд мэдээлж байна.



**Шагнал, урамшуулал:**



2018 онд төрийн одон, медаль, салбарын “Тэргүүний ажилтан”-аар шагнуулахаар 4 ажилтны тодорхойлолтыг холбогдох байгууллагад хүргүүлснээс дараах 3 ажилтан шагнагдлаа. Үүнд:

“Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол тэмдгээр: Аудитор Б.Эрдэнэзул, “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдгээр: Ахлах аудитор С.Баасансүрэн, Ц.Отгонбаяр нар тус тус шагнагдсаныг тус газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа гардуулав.

### **Бусад байгууллагатай харилцан хамтын ажиллагаа:**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 онд төрийн аудитын байгууллагын чиг үүргийн хүрээнд төр, төсвийн бусад байгууллагатай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Аймгийн ЭМГ-аас “Эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалтнууд болон эмийн сангийн эрхлэгч”-д 04-р сарын 10-нд зохион байгуулсан сургалтад ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, С.Баасансүрэн нар оролцон 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, цаашид анхаарах асуудлууд, сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн эрсдэлийн аудитын дүнгийн талаар танилцуулж, зөвлөгөө өгөв.
- Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 06-р сарын 06-нд зохион байгуулсан “Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах нь” сэдэвт зөвлөгөөнд аудитын менежер Б.Батмөнх, ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ нар оролцон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, цаашид анхаарах асуудал сэдвээр мэдээлэл өгөв.
- Орон нутаг хариуцсан орлогчийн ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу АТГ-аас Сэлэнгэ аймагт ирсэн ажлын хэсгийнхэнтэй аудитор Б.Эрдэнэзул 10-р сарын 22-24-ны өдрүүдэд хамтран ажиллаж, тус газраас гүйцэтгэсэн аудитын тайлан, дүн, зөрчлийн талаар мэдээлэл өгч, мэргэжлийн туслалцаа үзүүлэв.
- АТГ-аас ирүүлсэн 2018 оны 07/8239 дугаар албан бичиг, Орон нутаг хариуцсан орлогчийн ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу, хийж гүйцэтгэж буй аудитын хүрээнд Жавхланта сумын 2017, 2018 оны төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалт, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг шалгаж, тайлбар хүргүүлэв.
- Аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран аймгийн хэмжээний 17 сумын төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нар, бүртгэл санхүүгийн ажилтнуудыг хамруулсан бүсчилсэн зөвлөгөөнийг Мандал, Цагааннуур, Ерөө, Сайхан, Сүхбаатар гэсэн 5 бүсэд зохион байгуулж, “ Сэлэнгэ аймгийн төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны өнөөгийн

*байдал, аудитаар илэрсэн зөрчил” сэдвээр дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, “Аудитын мөрөөр цаашид авах арга хэмжээ” сэдвээр аудитын менежер Б.Батмөнх нар илтгэл тавьж, хэлэлцүүлэн, албан тушаалтнуудын асуусан асуултад хариу өгч, харилцан зөвлөлдөв.*

- *ҮАГ-ын холбогдох газруудаас зохион байгуулсан цахим хуралд бүрэн оролцож аудитын явц, үр дүнгийн талаар мэдээлэл хийлээ.*
- *Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан мод тарих, орчны цэвэрлэгээ хийх зэрэг 4 удаагийн нийтийг хамарсан ажилд хамт олноороо идэвхтэй оролцов.*

### **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:**

ҮАГ-ын 2018 оны 05-р сарын 03-ны өдрийн 01/1090 дугаар албан бичгээр тус газарт шилжүүлсэн “Бүрэндулаан” ХХК-ийн дулаан алдагдлын татаасыг олгохгүй байгаа талаарх, Сүхбаатар сумын иргэн н.Цогтбаатарын ирүүлсэн Сүхбаатар сумын ЗДТГ нь орон тоог хэтрүүлэн, багийн хэсгийн ахлагч ажиллуулж буй талаарх зэрэг 2 өргөдлийг тус тус шалган, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариу хүргүүлэв. Үүнд:

#### **1. “Бүрэндулаан” ХХК-ийн дулаан алдагдлын татаасын талаар:**

Бүрэндулаан ХХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 18/396 дугаар албан бичгээр ҮАГ-т хандан гаргасан хүсэлтэд дурдсан асуудлуудыг хянан шалгаад хариу өгөхийг ҮАГ-ын 5 дугаар сарын 03-ны өдрийн 06/1090 дугаар албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт шилжүүлсэн байна. Тус компанийн хүсэлтэд дурдсан дулааны алдагдлын татаасыг Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас нөхөн гаргуулах тухай асуудлыг холбогдох нотлох баримтын хүрээнд тулган шалгахад дараах байдалтай байна.

Сэлэнгэ-энерго ОНӨААТҮГ нь Эрчим хүчний зохицуулах хорооноос, Бүрэндулаан ХХК нь Сэлэнгэ аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс олгосон “Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах” тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.17-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хороо нь хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах бөгөөд мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4–д зааснаар Засгийн газар нь эрчим хүчний аюулгүйн нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нөөцийн жагсаалтыг тогтоож, баталсан байна.

Засгийн газраас 2016-2018 онуудад эрчим хүчний алдагдлын татаас, санхүүжилт олгохоор тогтоосон эрчим хүчний үйлдвэр, компаниуд, тэдгээрт олгох татаасын жагсаалтад “Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ-энерго ОНӨААТҮГ-500.0 сая” гэж нэр зааж оруулсан бол “Бүрэндулаан” ХХК –ийг нэр заан тусгаагүй байна. Үүнд:

- *Засгийн газрын 2015 оны “Төв, суурин газрын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 293 дугаар тогтоолын хавсралтаар Сэлэнгэ аймгийн дулааны станцуудын /“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ/ алдагдлын татаасыг 500.0 сая төгрөгөөр,*
- *Засгийн газрын 2016 оны “Төв, суурин газрын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 338 дугаар тогтоолын 1*

дүгээр хавсралтаар Сэлэнгэ аймгийн дулааны станцууд /“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ/-ын алдагдлын татаасыг 500.0 сая төгрөгөөр,

- Засгийн газрын 2017 оны “Төв, суурин газрын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ /Сэлэнгэ аймгийн дулааны станц/ -ын алдагдлын татаасыг 500.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр нэр заан тогтоосон байна.

Засгийн газрын дээрх тогтоолуудад нэр заагдсан эрчим хүчний үйлдвэр, дулааны станцуудын тухайн жилийн алдагдлын татаасыг улсын төсөвт суулган, батлагдсан төсвийн хүрээнд тухайн аж ахуйн нэгжийн /Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын/ харилцах дансанд санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Хэдийгээр Эрчим хүчний яамнаас Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-т ирүүлсэн 2017 оны 12 сарын 26-ны өдрийн в/4263, 2018 оны 3 сарын 27-ны өдрийн в/ 1038 дугаар бүхий албан бичгүүдээр тус үйлдвэрийн газарт дулааны алдагдлын татаасд жил бүр олгосон 500.0 сая төгрөгөөс 200.0 сая төгрөгийг нь Бүрэндулаан ХХК-д шилжүүлэх шаардлагатай гэсэн боловч Засгийн газрын дээрх тогтоолуудаар Бүрэн дулаан компанид дулааны алдагдлын татаас олгохыг нэр зааж тогтоогоогүй учир тусгайлан нэр заагдсан Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-т олгосон татаасаас Бүрэндулаан компанид дамжуулан шилжүүлэх үндэслэлгүй байна.

Иймээс цаашид дулааны алдагдлын татаас авах шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагуудаар уламжлуулан Засгийн газрын тогтоолоор жил бүр тогтоож буй дулааны алдагдлын татаас олгох эрчим хүчний үйлдвэр, дулааны станцуудын жагсаалтад Бүрэндулаан ХХК гэж нэр зааж тусгуулан, өөрийн компанийн харилцах дансаар санхүүжилтээ шилжүүлэн авч байх нь зүйтэй юм.

## **2. Сүхбаатар сумын багуудад хэсгийн ахлагч ажиллуулж байгаа талаар**

Иргэн Д.Цогтбаатарын өргөдөлд дурдсан Сүхбаатар сумын ЗДТГ нь 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулан баг бүрд 1-2 хүнийг хэсгийн ахлагчаар томилон төрөөс цалинжуулан ажиллуулж байгаа нь холбогдох хууль тогтоомжуудыг зөрчсөн эсэх асуудлыг нотлох баримтуудын хүрээнд тулган шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

Сүхбаатар сумын ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолоор тус сумын 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөөнөөс давсан 75,200.0 мянган төгрөгийн орлогоос баг тус бүрд ажиллах нийт 13 хэсгийн ахлагчийн урамшуулалд сар бүр 240.0 мянган төгрөгөөр тооцон 37,440.0 мянган төгрөгийг “Ангилалдаагүй бусад зориулалт”-ын зардлын ангиллаас олгохоор баталсан байна.

ИТХ-ын дээрх тогтоолыг үндэслэн сумын ЗДТГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр бүхий 13 иргэнийг хэсгийн ахлагчаар томилж, хөлсөөр ажиллуулах гэрээг 6 сарын хугацаатайгаар байгуулан, сард хүн тус бүрд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу 240,0 мянган төгрөгийн урамшуулал олгон ажиллуулж байна.

Багуудад хэсгийн ахлагч ажиллуулан, төрөөс урамшуулал олгох үйл ажиллагааг Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон бусад ямар нэгэн хууль, удирдах дээд шатны байгууллагуудын шийдвэрээр тогтоож өгөөгүй бөгөөд өөрөөр

хэлбэл дээрх үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актууд болон төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчимтай нийцэхгүй байна гэж үзээд холбогдох хууль, тогтоомжид нийцэхгүй хэсгийн ахлагч ажиллуулж, урамшуулал олгож, төсвийг үр ашиггүй төлөвлөж, зарцуулж байгаа зөрчлийг арилгах зөвлөмжийг сумын ЗДТГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **МУ-ын Ерөнхий аудиторын албан даалгаврын биелэлт**

Монгол Улсын Ерөнхий аудиторын “Ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгаж, ажлын чанар үр дүнг дээшлүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр боловсруулж, дарга, тэргүүлэх аудитораар батлуулан ажиллаж байна.

Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Ерөнхий аудиторын “Ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгаж, ажлын чанар үр дүнг дээшлүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг бүх ажилтнуудад танилцуулж, гарын үсгээр баталгаажуулав.
- Аудитын менежер, ахлах аудиторуудын зүгээс аудитын үе шатны ажлуудад чанарын хяналт тавьж, 7 хоног бүрийн баасан гаригт хийж гүйцэтгэсэн ажлыг хяналтын хуудсаар баталгаажуулж, дарга тэргүүлэх аудиторт танилцуулж байна.
- “Авлигын эсрэг хууль”, “ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг мэдээллийн самбарт байршуулж, дотоод сургалт зохион байгуулав.
- Төрийн аудитын байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрмийг мөрдөж ажилласнаар ажил таслах, хоцрох болон ямар нэгэн ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна.
- Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж байна.
- Тус газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсан аудитуудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүх хүргэж байна.
- Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны 3-р улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг гаргаж, 10 дугаар сарын 8-нд ҮАГ-т хүргүүлэв.
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн өөрийн орлогын 9,5 сая төгрөгийг зарцуулах эрхийг МУ-ын ерөнхий аудитораас авч, суурин компьютер 3 ширхэг, принтер 3 ширхгийг тус тус худалдан авч, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийсэн бөгөөд 5 өрөө, тасалгааны хаалга, шал, цонх, хөшиг солих, эмульс, будаг, шохойг шинэчлэх, гэрэлтүүлэг, цахилгааны утас солих зэргээр урсгал засвар хийв.
- Байгууллагын батлагдсан төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөндлөнгийн аудитын дүгнэлт болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд нь *Shilen dans.gov.mn* нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээс гадна өөрийн байгууллагын “ Ил тодын самбар”-аар нийтэд мэдээлэв.
- Төсөв, санхүүгийн холбогдох 110 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, хаягийг Шилэн данс цахим нэгдсэн хуудсанд байршуулаад байна.



- Өөрийн аудиторуудын мэдлэг чадварын дээшлүүлэх зорилгоор Мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөний хүрээнд дотооддоо нийт 6 сургалт зохион байгуулав.
- Сэлэнгэ аймагт АТГ-аас Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдалтай танилцах, зөвлөмжийн биелэлтийн явцыг шалган туслах, худалдан авах ажиллагааг хянан шалгах, аймгийн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах, иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийнхэнтэй хамтран ажиллаж, өөрийн гүйцэтгэсэн аудитын тайлан, дүн, зөрчлийн талаар мэдээлэл хүргүүлсэн бөгөөд, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний хэрэгжилтийг шалгаж, товч тайлбар хүргүүлэв.
- Албан хэргийн журам, стандартын дагуу баримт бичгийг хөтлөн , баримт бичгийг нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, 131 хавтас материалыг байгууллагын архивд хүлээлгэн өгөв.
- Ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, үүрэгт ажлаа чанартай үр дүнтэй хийж гүйцэтгэн, ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлж, ажлын байран дэг журмыг мөрдөн ажилласнаар тайлант хугацаанд ажилтнууд сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй болно.

### **Ажилтнуудын нийгмийн асуудлын шийдвэрлэлт**

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-д заагдсан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газрын ажилтнуудын хүүхдүүдийг бэлэг дурсгалын зүйлээр урамшуулав.
- Батлагдсан төсвийн хүрээнд сар бүр ажилтнуудад тус бүр 30.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгов.
- Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн аудитор Ж.Цогтод 200.0 мянган төгрөгийн тусламж, тэтгэмж олгов.
- Байгууллагын ажилтнуудын өвөлжилтийн бэлтгэл хангахад зориулж түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 500.0 мянган төгрөгийн тэтгэмж олгов.
- Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахлах аудитор Б.Наранчимэгт 200.0 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл гардуулав.
- Шинэ жилийн баярыг тохиолдуулан бүх ажилтнуудад тус бүр 20.0 мянган төгрөгийн өрхийн бэлэг олгов.
- Тус газрын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 167 дугаар албан бичгээр нийт ажилтнуудыг Улаанбаатар хотын нарийн мэргэжлийн эмнэлэг, эмчийн үзлэгт хамруулж, зөвлөгөө өгүүлэх хүсэлтийг Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогч С.Бүрэнбатад хүргүүлэв.

### **Нийгэм, соёл, спорт, бусад арга хэмжээний оролцоо**

- Санхүү, бүртгэлийн ажилтнуудын өдөрт зориулан аймгийн төвийн санхүү, бүртгэлийн чиглэлийн байгууллагуудын дунд зохиогддог спортын уламжлалт тэмцээнд тус газрын албан хаагчид сагс, волейбол, дартс, шатар, ширээний теннисний төрөлд оролцож, дартсын төрөлд эмэгтэй 1 дүгээр байр, сагсан

бөмбөгийн төрөлд тус газрын эрэгтэйчүүдийн оролцсон баг 3 дугаар байр эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.



- Аймгийн Засаг даргын нэрэмжит сумдуудын дунд зохион байгуулагдсан спортын наадамд тус газрын аудитор А.Дашбат, Ж.Цогт нарын оролцсон Сүхбаатар сумын баг 1 дүгээр байр эзлэн, 2018 оны аваргын цом гардав.
- Тус газрын хамт олны санаачлагчаар “Сайн үйлсийн аян” зохион байгуулж, хамт олны хандиваар Сүхбаатар сумын 1 дүгээр багийн 6 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйн гэр бүлд тусламж болгон, түлээ, нүүрс, гурил, будаа, бүтэн хонины мах, ургамлын тос зэрэг 300.0 мянган төгрөгийн үнэ бүхий өргөн хэрэглээний эд бараа, гардуулан өглөө.



### Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагаанд 250.8 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд санхүүжилтийг бүрэн авч, 2 орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан гүйцэтгэлээр 242.8 сая төгрөг зарцуулан, 8.0 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдлаа.

Нийт зардлын гүйцэтгэлийн 76.0 хувийг цалин, НДШ-ийн зардал, 24.0 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал эзэлж байна.

Байгууллагын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд “Улаанбаатар аудит” компаниар аудит хийлгэн **“Зөрчилгүй”** санал дүгнэлт авсан болно.

Байгууллагын 2018 оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж, дарга, тэргүүлэх аудиторовын 2018 оны А/05, А/21 дугаар тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” 2 удаа хөрөнгийн тооллого явуулж, эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв.

МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/175 дугаар тушаалаар нэмэлт орлогыг зарцуулах эрх олгосны дагуу үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 9.5 сая төгрөгөөр аудиторуудын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн 3 компьютер, 3 принтер худалдан авсан ба 5 өрөө тасалгаанд урсгал засвар хийлээ.

Ашиглалтын хугацаа дуусаж, ажлын шаардлага хангахгүй болсон 6.3 сая төгрөгийн анхны үнэ бүхий 8 ширхэг суурин компьютерыг актлуулах саналыг ҮАГ-т хүргүүлэв.

Байгууллагын эзэмшилд ашиглагдаж байгаа Prado-120 авто машины засвар үйлчилгээг тогтмол хийж, төсвийн хөрөнгөөр өвлийн 4 дугуй болон бусад сэлбэгийг солиулан, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллав.

НДШ, татварын тайлангуудыг хуулийн хугацаанд нь гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн болон 2018 оны улирлын санхүүгийн тайлангууд, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2019 оны төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлийг тогтоосон хугацаанд нь тус тус гаргаж, ҮАГ-т хүргүүлсэн болно.

### ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь төрийн аудитын байгууллагын системийн хэмжээд тодорхойлсон **“Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх”** зорилт болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, Монгол улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

ҮАГ-ын Тамгын газар болон Монгол улсын Ерөнхий аудиторын орон нутаг хариуцсан орлогчийн ажлын албанд дараах санал, хүсэлтийг уламжилж байна. Үүнд:

*1. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын нийт ажилтнуудын 60 хувь нь буюу 6 ажилтан орон сууцны 8 хувийн ипотекийн зээлд хамрагдаж, нийт 220.0 сая төгрөгийн зээлтэй байгаа тул төрийн аудитын байгууллагад ажилласан жил, ажлын үр дүнг харгалзан хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу орон сууцны хөнгөлөлтөд ээлж дарааллаар хамруулах.*

*2. Өнөөгийн байдлаар тус газарт үүссэн аудиторын 2 сул ажлын байранд сонгон шалгаруулалт зарлан, нөхөх арга хэмжээ авах.*

*3. 2018 оны байдлаар ажилтнуудын хоол, унааны хөнгөлөлтөд өдрийн 1500 төгрөг олгож байгаа бөгөөд 2019 оны төсөвт уг хөнгөлөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, санхүүжүүлэх.*

*4. Бичиг хэрэг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бензин шатахууны зардлыг хийж гүйцэтгэж буй аудиттай уялдуулж, нэмэгдүүлэн төлөвлөж, санхүүжүүлэх зэрэг болно.*

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ